



ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ

2018.10.16, МЯГМАР ~ №203 (1002)

~ СОЁЛТ ХҮНИЙ ӨГЛӨӨ СОНИН УНШИХААС ЭХЭЛДЭГ ~

ҮНЭ: 1000Т

Газрын тосны үйлдвэрийн дэд бүтцийн ажил 40 хувьтай байна

1.4 сая тонн цемент үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг. > 2

FT ШИЛДЭГ НИЙТЛЭЛҮҮД ТАНД ХҮРЧ БАЙНА > 9

FINANCIAL TIMES

Монголд хонины ноосноос ноолуур гарган авдаг боллоо

Шинэ брэнд гаргах хамгийн боломжтой зах зээл нь хойд хөрш юм. > 11

ZGM DAILY FULL ENGLISH PAGE INSIDE > 7

ОНЦЛОХ

УЛС ТӨР
АН: Монголбанкт хамтрах-гүйгээр Засгийн газар дангаараа ипотека хэрэгжүүлэх боломжгүй. **Хүүхдийн мөнгийг нийт** хүүхдэд олгох төслийг ТББХ-руу шилжүүлэв. **Ерөнхий сайд газрын тосны** үйлдвэрийн дэд бүтцийн ажилтай танилцлаа. **Сайд Н.Цэрэнбат яндангийн** шүүлтүүрийн талаар өнөөдөр тайлбар өгнө.

ЭДИЙН ЗАСАГ
Дархан-Уул аймагт үнэт металлын сорьц тогтоох лаборатори нээгдлээ. **ОУВС-гийн уулзалтаар** ЗГ-уудыг хүндээ хөрөнгө оруулахыг уриаллаа. **МХБ-д бүртгэлтэй компаниудын** 88 хувь нь арилжаанд оролцож байна. **Топ 20 индекс 20,463.69** нэгж болж, 0.69 хувиар өсөв.



НИЙГЭМ
Халх гол сумыг шинэчлэх "Шинэ сум" төслийн бүтээн байгуулалтын ажил эхэллээ. **Улаанбаатар дахь эрүүл мэндийн** байгууллагуудыг түргэний машинтай болгох төслийг батлав. **Аврагчид гэрээсээ төөрсөн** таван настай хүүг хаднаас унасан, осголтын байдалтай олжээ. **НИТХ-аас Налайх дүүрэгт өсвөр** насны охидын хөгжил, хамгаалалд зориулсан танхим нээв.

ДЭЛХИЙ
ЕХ-ны дээд уулзалтад Орос, Хятадын Ерөнхий сайд нар ирэх гэж байна. **Британи Оросын эсрэг химийн** зэвсэг, цахим халдлагын хориг тавихыг уриалав. **Тайланд 2021 оноос хог** хаягдлаа боловсруулахаар пластик импортлохоо зогсооно. **ЕХ машины батарей үйлдвэрлэх** төслүүдэд олон тэрбум еврогийн санхүүжилт олгохоо зарлав. **Туркийн Ерөнхийлөгч сөрөг** намын банкны активыг хураах хууль санаачилжээ.

ЦАГ АГААР

УЛААНБААТАР
 2018.10.16

14° | 0°

БАГАВТАР ҮҮЛТЭЙ

ЦАГ АГААРЫН ДЭГЖЭВЧ ГҮЙ МЭДЭЭЛИЙГ 8 ДУГААР НУУРГУУС УНШИНА УУ.

8 658 000 029 112 0 10 02

Бүх эрх хуулиар хамгаалагдана ©

ХҮН ТӨВТЭЙ БИЗНЕСИЙН ХААНЧЛАЛ АЙСУЙ



Эдийн засаг өсөж буй энэ үед компаниудад хамгийн хэрэгтэй гурван зүйлийн нэг нь чадварлаг боловсон хүчин. Тэдний ид шидийг амилуулахын тулд дуртай амттан, спорт тоглоом, тав тухтай орчин, цагийн уян хатан зохицуулалтад анхаарах нь компанийг хөгжилд хөтлөх шинэ чиг хандлага болж байна. > 5

НИЙТЛЭЛЧИЙН БУЛАН Сумдын тоог цөөлж, төсвийн нурууг тэнийлгэе

П.Батбөх
 ЗГМ

Орон нутгийн хөрөнгө оруулалт их наядаар тоологдох хэмжээнд хүрлээ. Хүн амын тархмал байдлаас болж татвар төлөгчдийн хөрөнгө жил ирэх тусам үр ашиггүй зүйлд улам их зарцуулагдах болсон нь эндээс шууд харагдана.

Үндэсний статистикийн хороо (ҮСХ)-ны мэдээллээр 1996 онд Монгол Улсын нийт хүн амын 50 гаруй хувь нь хөдөө орон нутагт амьдарч байсан бол нийслэлийг чиглэсэн шилжих

хөдөлгөөнөөр сумдад амьдрах хүн амын тоо эрс буурсан. Орон нутгийн хүн амын тоо 2000 онд нийт хүн амын 44 хувь байсан бол 2013 гэхэд 31 хувь болтлоо эрс буурчээ.

Сүүлийн 10 жилд гэхэд нийслэлд албан ёсоор шилжин ирэгсдийн тоо 490 мянгаар нэмэгдэж, 2.14 саяд хүрлээ. Үүн дээр сумдаас ажил хайж, амьдрал бараадаж ирэгсдийг тооцвол нийт хүн амын 25 хүрэхгүй хувь нь орон нутагт амьдарч буй.

> 3

ЗГМ: ЗОЧИН Хуулийн дагуу ажиллаж байхад хэн ч дарамт үзүүлж чадахгүй байх

Г.Баярсайхан
 @bayarsaikhanZGM

Цагдаагийн байгууллага шилдэг мөрдөгчдийг шалгаруулж эхэлснээс хойш 25 жил өнгөрчээ. Өнөө жилийн тэмцээн өнгөрсөн өсдөгээр сард болоход Мөрдөн байцаах албаны Хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтсийн ахлах мөрдөгч, ахлах дэслэгч М.Батсайхан түүрүүлсэн юм. Цагдаагийн албаны шилдэг залуу боловсон хүчний төлөөлөл болж буй түүнтэй ярилцлаа. Тэрбээр түүрүүлсэн тэмцээнээс гадна мөрдөгчийн ажлын зовлон жар-

гал, ажлын ачаалал болон цалин хангамжийн талаар өгүүлсэн юм.

-Шилдэг мөрдөгч шалгаруулах уралдааны энэ жилийн ялагч нь болжээ. Энэ уралдааны талаар ярилцлагаа эхлэх үү?

"Шилдэг мөрдөгч 2018" тэмцээн өнгөрсөн өсдөгээр сард болсон. Энэ жил 25 дахь удаагаа зохиогдсон юм. Тэмцээний тухайд хууль эрх зүй, гадаад хэл, компьютерийн мэдлэг шалгах, сэтгэн бодох чадвар сорих, бие бялдрын сорилт болон буудлага үйлдэх гээд олон төрөлтэй.

> 6

ARD | ДААТГАЛ
 SINCE 1994

"АРД ДААТГАЛ" ХК-ИЙН ТУЗ-ИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН ЗАР

Компанийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.1, 81.2 дахь заалтыг үндэслэн "Ард Даатгал" ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг зарлаж байна.

ТАВИГДАХ ШААРДЛАГА:

- НББ, эдийн засаг, хууль эрх зүй, банк санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлийн мэргэжилтэй эсвэл хослон эзэмшсэн, дадлага туршлагатай;
- Тус компанитай ижил төрлийн үйл ажиллагаа явуулдаг, өрсөлдөгч аж ахуйн нэгжийн удирдлагад ажилладаггүй байхаас гадна ижил төрлийн бизнесийн үйл ажиллагаа эрхлэхээр зөвшөөрөл хүссэн өргөдөл Санхүүгийн зохицуулах хороонд гаргаагүй;
- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран компанийн нийт гаргасан хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэггүй;
- Өөрөө болон нэгдмэл сонирхолтой этгээд нь компанийн өнгөрсөн жилийн нийт борлуулалтын 1 хувиас дээш хэмжээний үнийн дүн бүхий хэлцлийг компанитай хийж байгаагүй;
- Өөрөө, эсхүл нэгдмэл сонирхолтой этгээд нь компанид болон компани оролцогч нь болж байгаа нэгдлийн бусад оролцогч компанид эрх бүхий албан тушаал хашдаггүй, эсхүл сүүлийн 3 жилд тийм албан тушаал хашаагүй;
- Компанийн эрх бүхий албан тушаалтантай нэгдмэл сонирхолгүй, тэдгээрийн төрөл, садан, гэр бүлийн гишүүн биш;
- Төрийн үйлчилгээнээс бусад төрийн алба хашдаггүй.
- Англи хэлний бичгийн болон ярианы өндөр чадвартай.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТАНД ОРОЛЦОХЫГ ХЯЗГААРЛАХ НӨХЦӨЛ

- Өмнө нь мэргэжлийн болон ёс зүйн ноцтой зөрчлийн улмаас хуулийн хариуцлага хүлээж байсан;
- Тодорхой албан тушаал эрхлэх, эсвэл үйл ажиллагаа явуулах эрхийг нь шүүхийн шийдвэрээр хассан, эрүүгийн хуульд заасан онц гэмт хэрэг үйлдэж шүүхээр ял шийтгэл хүлээж байсан.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

- Компанийн "ТУЗ-ийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хороо"-ны нэр дээр гаргасан сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт.
- Анкет (Вэб сайтаас татаж авах)
- Боловсролын дипломын хуулбар;
- Иргэний үнэмлэхний хуулбар;
- Цээж зураг;
- Компанийн засаглалын сургалтад хамрагдсан гэрчилгээний хуулбар;

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛЫГ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ:

Хүсэлтийг 2018 оны 10 сарын 26-ны өдөр 14:00 цаг хүртэл "Ард Даатгал" ХК-ийн байранд хүлээн авах бөгөөд ardaa@arddaatgal.mn хаяг руу хуулбарыг илгээнэ. Урьдчилсан шалгуурт тэнцсэн нэр дэвшигчдийг хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулж шийдвэрлэнэ.

Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж 2, 7220 0088

Хүчтэй. Хамтдаа.

АЛТ 1232.77 1.29%	ЗЭС 6302 0.96%	10-ЧИНГИС БОНД 95.946 0.79%	ХУРАЛДАЙ БОНД 110.04 0.00%	ГЭРЭГЭ БОНД 97.170 0.01%	АМ.ДОЛЛАР 2564.65	ЮАНЬ 370.22	РУБЛЬ 39.01
--------------------------------	-----------------------------	--	---	---------------------------------------	-----------------------------	-----------------------	-----------------------

Улс төр

БҮЛЭГ

Д.Эрдэнэбат: Өрийн асуудал өрх бүрийн хаалгыг ТОГШИЖ ЭХЭЛЛЭЭ

Б.Энх
ЗГМ

“Монголбанктай хамтрахгүйгээр зөвхөн Засгийн газар ипотека хэрэгжүүлэх боломжгүйг өнгөрсөн нэг жилийн хугацаа нотоллоо” хэмээн Ардчилсан намын бүлгийн дарга Д.Эрдэнэбат хэллээ. Төрөөс мөнгөний бодлогын талаар баримтлах үндсэн чиглэлийг хэлэлцэж эхэлсэнтэй холбогдуулан тус намын бүлэг Монголбанкны удирдлагуудаас мэдээлэл авчээ.

Улмаар 2018 оны үндсэн чиглэлээс биелэгдээгүй хэд хэдэн чухал асуудал байна гэж дүгнэжээ. Монголбанкны өгсөн мэдээллээр энэ жил ипотекийн зээлд зориулж 200 тэрбум

төгрөгийг банкуудад нийлүүлсэн ч бодит байдал дээр барилгын үйлдвэрлэл огцом буурсан. Учир нь ипотека зориулсан мөнгө хуучин барилгын өр хаахад зориулагдсан. Үүнийг Монголбанкныхан хүлээн зөвшөөрсөн гэж Д.Эрдэнэбат хэлсэн юм.

Мөн чанаргүй зээл, зээлийн хүүгийн дарамтын асуудал 2018 оны үндсэн чиглэлд тусгагдсан гол заалт байтал хэрэгжилт тун хангалтгүй байсан гэв. 2018 оны үндсэн чиглэлээс хэрэгжээгүй гол чиглэл нь эдийн засгийн өсөлт иргэдийн амьдралд мэдрэгдээгүй гэж дүгнэв.

Түүнчлэн Монголын эдийн засагт хэд хэдэн дарамт байгаагийн эхнийх нь улсын гадаад дотоод өр. Мөн чанаргүй зээл

нэмэгдсэн, арилжааны банкуудаас авч буй нийт зээлийн дийлэнх нь хэрэглээнийх байгааг тайлбарлалаа.

Зээлийн бүтцийг задалбал, нийт зээлийн 28 хувийг хэрэглээний зээл эзэлсэн байна. Харин худалдаанд 15, үл хөдлөх хөрөнгөд 12 хувь нь зориулагджээ.

Гэтэл үйлдвэрлэлийн зориулалттай аж ахуйн нэгжийн зээлийн тухайд хөдөө аж ахуйд нийт зээлийн хоёр хувь, уул уурхайд найм, боловсруулах үйлдвэрт 10 хувь нь очсон байна. Өөрөөр хэлбэл, нийт зээлийн 20 хувь л үйлдвэрлэлд зориулагдсан гэсэн үг. Тиймээс энэ асуудлыг Монголын Засгийн газар зайлшгүй анхаарч, Төрөөс мөнгөний талаар баримтлах бодлогын баримт бичгээ гаргах ёстой гэсэн юм.



Б.Хасуй / ЗГМФ

ТОВЧХОН

» ЕРӨНХИЙЛӨГЧ

Халх голын тулалдааны 80 жилийн ойг ирэх жил ОХУ-тай хамтран тэмдэглэх ажлын хүрээнд Халх гол сумын төвийг шинэчилж, сум дундын бүтээн байгуулалт буюу “Шинэ сум” төслийг тус сумд хэрэгжүүлэхээр боллоо. Мөн ОХУ 10 орчим сая ам.доллартай тэнцэх санхүүжилтийг шийдвэрлэхээ илэрхийлсэн юм. Гэвэл Халх гол сумыг төсвийн бус хөрөнгөөр шинэчлэх бүтээн байгуулалтын ажил албан ёсоор эхэлж, шав тавих ёслол боллоо.

» АЙЛЧЛАЛ

Бүгд Найрамдах Тажикстан улсын Душанбе хотноо болсон ШХАБ-ын Засгийн газрын тэргүүн нарын уулзалтад Шадар сайд Ө.Энхтүвшин оролцожээ. Тэрбээр Тажикстан, Кыргыз, Казахстан улсын Ерөнхий сайдуудтай уулзаж, хоёр орны хамтын ажиллагааны талаар санал солилцсон байна.

» НАМУУД

Ардчилсан намын эмэгтэйчүүдийн байгууллага тэргүүнээ дотоод сонгуулиар тодруулах сунгаа ид өрнөж буй. Тус албан тушаалд нэр дэвшиж буй С.Одонтуяа, Ц.Цэрэндолгор, Т.Пүрэвхатан нар хамгийн сүүлд Баян-Өлгий аймгийн намын гишүүд, дэмжигчидтэй уулзалт хийжээ. Баян-Өлгий аймгийн эмэгтэйчүүд тулгамдаж буй ажилгүйдэл, ядуурлын түвшинг бууруулах чиглэлээр дорвитой алхам хийж, эмэгтэйчүүдийг ажилтай, орлоготой байлгахын төлөө ажиллахыг нэр дэвшигчдээс хүссэн байна.

Д.Хаянхярваа: Хүссэн хүүхэд бүрт мөнгөн тэтгэмж олгох боломжтой



Бүх хүүхдэд мөнгө олгоход 27 тэрбум төгрөг шаардлагатай

Хүүхдийн мөнгөн тэтгэмжийг хүссэн хүүхэд бүрт олгох асуудлыг Төсвийн байнгын хороогоор хэлэлцэх нь зүйтэй гэж МАН-ын бүлэг үзжээ.

С.Бямбацогт нарын гишүүдийн өргөн барьсан уг төслийг МАН-ын бүлгээр хэлэлцэх үеэр Засгийн газар ОУВС-тай байгуулсан гэрээгээ баримтлах ёстой гэсэн саналыг

зарим гишүүн гаргасан аж. Гэвч нийт хүүхдийн 80 хувьд олгох одоогийн төсвөөс чөлөөт мөнгөн үлдэгдэл үлддэг тул, хүсэлт гаргасан хүүхэд бүрт олгосон ч нэмэлт төсвийн эх үүсвэр шаардагдахгүй гэж ХНХ-ын сайд С.Чинзориг хэлсэн байна.

УИХ дахь МАН-ын бүлгийн дарга Д.Хаянхярваа “Нийт хүүхдийн 80 хувь буюу 900 мянга гаруй хүүхэд мөнгөн тэтгэмж олгох зохицуулалттай. Гэвч 60 орчим хувь нь мөнгөн тэтгэмж авч байгаа” гэсэн юм.

Харин Засгийн газраас өргөн барьсан төсвийн төслийн талаар тэрбээр “Сонгуулийн өмнөх жилийн төсвийг

батлахад хэл ам нэлээд гардаг. Гэхдээ өнөөдөр нийгэмд яригдаад байгаа шиг 2019 оны төсөв бүхэлдээ сонгууль руу чиглэсэн, эдийн засгаа баллах хэмжээнийх биш. Бид ирэх оны төсвийн орлогыг есөн их наяд төгрөгөөр төсөөлсөн. Улсын төсвийн төслийн Ажлын хэсэг байгуулагдаж, ойлголцлын түвшинд явж байгаа. Гишүүд тойрог бүрт таван тэрбум төгрөг авсан гэх яриа бий. Гэхдээ энэ бол гишүүний мөнгө биш. Үүнийг орон нутгийн удирдлага захиран зарцуулна. Түүнээс бус УИХ-ын гишүүд захиран зарцуулахгүй, харин хяналт тавина” гэв. [ЗГМ]

ЗАСГИЙН ГАЗАР

Газрын тосны үйлдвэрийн дэд бүтцийн ажил 40 хувьтай байна

1.4 сая тонн цемент үйлдвэрлэж, дотоодын хэрэгцээгээ бүрэн хангадаг

Г.Сэлэнгэ
ЗГМ

Ерөнхий сайд У.Хүрэлсүх өчигдрөөс Дорноговь аймагт ажиллаж байна. Тэрбээр “МАК” ХХК-ийн “Евро блок” болон тус компанийн “Хөх цав” цемент, шохойн үйлдвэртэй танилцсан юм.

2015 онд ашиглалтад орсон “Евро блок” үйлдвэр хоногт 900 шоо метр блок үйлдвэрлэж, импортын хэрэгцээний 30 орчим хувийг хангаж байна.

Манай улсын цементийн хэрэгцээ жилд 1.8 сая тонн байдаг. Саяхныг болтол үүний нэг сая тонныг импортоор оруулж ирдэг байв. Засгийн газар дотоодын барилгын материалын үйлдвэрүүдийг бодлогоор дэмжсэний үр дүнд манай улс өнөөдөр 1.4 сая тонн цемент үйлдвэрлэж, дотоодын зах зээлд нийлүүлж буй “Хөх цав” үйлдвэр 2017 оноос ажиллаж буй аж.

Ерөнхий сайд дараа нь Дорноговь аймгийн Алтанширээ



суманд ажиллаж, Газрын тос боловсруулах үйлдвэрийн бүтээн байгуулалттай танилцлаа.

Газрын тос боловсруулах үйлдвэр байгуулах ажлыг эхлүүлж, дэд бүтцийн барилгын ажлын суурийг өнгөргөж зургадугаар сард тавьсан. Өнөөдрийн байдлаар дэд бүтэц буюу автозам, төмөр зам, цахилгаан дамжуулах шугамын ажил нийт 40 хувьтай өрнөж байна. Энэхүү бүтээн байгуулалтад 500 гаруй хүн, 260 гаруй машин механизм ажиллаж байгааг “Монгол газрын тос боловсруулах үйлдвэр” ТӨХК-ийн удирдлагууд Ерөнхий сайдад танилцуулсан байна.

Төмөр зам, авто зам, цахилгаан дамжуулах шугамын ажлын бүтээн байгуулалтад монголчууд ажиллаж буй бөгөөд орон нутгаас 120 гаруй

ажилчин ажиллуулж, орон нутгийн аж ахуйн нэгжүүдээс 800 сая төгрөгийн бетон зуурмаг, хэв хашмал, цемент, хайрга, барилгын бусад материалууд, нийт ажилчдын хэрэглэх хоол хүнс, ахуйн барааг худалдан авч, орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулж буй аж.

Тус үйлдвэрийг Дорноговь аймгийн Сайншанд сумаас зүүн хойд зүгт 18 км-т Алтанширээ сумын нутаг дэвсгэрт 150 га талбайд барьж байна. Жилд 1,5 сая тонн газрын тос боловсруулах хүчин чадалтай ба эхний тогтоогдсон түүхий эдийн нөөц 40 жил юм. Санхүүжилтийн өртгөө ашиглалтад орсноосоо хойших эхний 10 жилд бүрэн нөхөх боломжтой. Тус боловсруулах үйлдвэрийг 2022 онд бүрэн ашиглалтад хүлээлгэн өгөхөөр төлөвлөж байна. [ЗГМ]

УЛААНБААТАР ХОТ ДАХЬ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХЭД БОЛОН ИРГЭДИЙН ЗОРЧИХ БОЛОМЖИЙГ НЭМЭГДҮҮЛЭХ ТӨСӨЛ

Уг төсөл нь 2017.2-2018.11 дүгээр сар хүртэл нийт 2 жил үргэлжлэх төсөл юм. Протез ортопедийн мэргэжлийн техникч бэлтгэх, хүүхдийн сэргээн засалч бэлтгэх, мэргэжлийн ур чадварыг сайжруулах сургалтаар дамжуулан ХБ-тэй иргэд, хүүхдүүдийн өвчлөл болон зовуурыг багасгах, сэргээн засах үйлчилгээний хүртээмжийн орчныг сайжруулах, зорчих боломжийг нэмэгдүүлэхэд бид зорилт тавин ажиллаж байна. Мөн практик сургалтаар сурагчид ХБ-тэй иргэдээс шууд хэв аван протез, ортопедийн хэрэгслийг хийж үйлдвэрлэн суралцаж байгаа билээ.

Мөн энэ оны 10 сард ХБ-тэй иргэдэд зориулсан протез, ортопедийн сүүлийн үеийн хэрэгсэл, хэрэглэгдэхүүний талаар мэргэжлийн техникч нар үнэ төлбөргүй зөвлөгөө, мэдээлэл өгөх арга хэмжээ, протез ортопедийн үзэсгэлэн олон нийтэд нээлттэй зохион байгуулагдах тул та бүхэн өргөнөөр оролцож, зочилно уу.

Протез, ортопедийн үзэсгэлэн	Үнэ төлбөргүй зөвлөгөө																																																
<p>Зорилго</p> <ul style="list-style-type: none"> - Протез, ортопедийн техникч бэлтгэх сургалтаар сурагчдийн хийж гүйцэтгэсэн бүх хэрэгсэлүүдийг үзэсгэлэн болгон гаргах - Протез ортопедийн хэрэглэгдэхүүний талаар техникч нар ирсэн зочдод мэдээлэл, зөвлөгөө өгч танилцуулах <p>Зорилтот бүлэг</p> <ul style="list-style-type: none"> - Протез, ортопедийн хэрэглэгдэхүүний талаар мэдээлэл авахыг хүссэн бүх хүмүүст /МУ-ын иргэн, холбогдох төрийн болон төрийн бус байгууллагууд/ <p>Хэзээ</p> <p style="text-align: right;">2018.10.24</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th colspan="4" style="text-align: center;">Улаанбаатар хот дахь ХБ-тэй хүүхэд болон иргэдийн зорчих боломжийг нэмэгдүүлэх төсөл</th> </tr> <tr> <th colspan="4" style="text-align: center;">Протез, ортопедийн үзэсгэлэний танилцуулга</th> </tr> <tr> <th>Тайлбар</th> <th>Мандчиглээ</th> <th>Ганчимэг /Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дарга/</th> <th>Хуан Гван Шиг /Солонгосын ХБ-тэй иргэдийн холбооны тэргүүн/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>13:00</td> <td>Мандчиглээ</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>13:10-13:20</td> <td>Төслийн танилцуулга /Бичлэг үзэх/</td> <td>Ч.Ундрахбаяр /Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвийн захирал/</td> <td></td> </tr> <tr> <td>13:20-18:00</td> <td>Протез, ортопедийн үзэсгэлэн</td> <td>Солонгосын DPI, Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв, техникч багш нар</td> <td></td> </tr> </tbody> </table>	Улаанбаатар хот дахь ХБ-тэй хүүхэд болон иргэдийн зорчих боломжийг нэмэгдүүлэх төсөл				Протез, ортопедийн үзэсгэлэний танилцуулга				Тайлбар	Мандчиглээ	Ганчимэг /Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дарга/	Хуан Гван Шиг /Солонгосын ХБ-тэй иргэдийн холбооны тэргүүн/	13:00	Мандчиглээ			13:10-13:20	Төслийн танилцуулга /Бичлэг үзэх/	Ч.Ундрахбаяр /Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвийн захирал/		13:20-18:00	Протез, ортопедийн үзэсгэлэн	Солонгосын DPI, Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв, техникч багш нар		<p>Зорилго</p> <ul style="list-style-type: none"> - Сургалтын хөтөлбөрөөс гадна ХБ-тэй иргэдийн протез, ортопедийн хэрэглэгдэхүүний талаарх холбогдох бус нутгийн эрэлт хэрэгцээг судлах - МУ-ын ХБ-тэй иргэдэд протез, ортопедийн сүүлийн үеийн мэдээлэл олгох <p>Зорилтот бүлэг</p> <ul style="list-style-type: none"> - Протез, ортопедийн хэрэглэгдэхүүний талаар мэдээлэл авахыг хүссэн ХБ-тэй иргэд <p>Хэзээ</p> <p style="text-align: right;">2018.10.24</p> <table border="1" style="width: 100%; border-collapse: collapse;"> <thead> <tr> <th colspan="4" style="text-align: center;">Улаанбаатар хот дахь ХБ-тэй хүүхэд болон иргэдийн зорчих боломжийг нэмэгдүүлэх төсөл</th> </tr> <tr> <th colspan="4" style="text-align: center;">Үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх танилцуулга</th> </tr> <tr> <th>Тайлбар</th> <th>Мандчиглээ</th> <th>Ганчимэг /Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дарга/</th> <th>Хуан Гван Шиг /Солонгосын ХБ-тэй иргэдийн холбооны тэргүүн/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>13:00</td> <td>Мандчиглээ</td> <td></td> <td></td> </tr> <tr> <td>13:10-13:20</td> <td>Төслийн танилцуулга /Бичлэг үзэх/</td> <td>Ч.Ундрахбаяр /Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвийн захирал/</td> <td></td> </tr> <tr> <td>13:20-18:00</td> <td>Протез, ортопедийн үнэ төлбөргүй зөвлөгөө</td> <td>Солонгосын DPI, Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв, сурагчид болон техникч багш нар</td> <td></td> </tr> </tbody> </table>	Улаанбаатар хот дахь ХБ-тэй хүүхэд болон иргэдийн зорчих боломжийг нэмэгдүүлэх төсөл				Үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх танилцуулга				Тайлбар	Мандчиглээ	Ганчимэг /Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дарга/	Хуан Гван Шиг /Солонгосын ХБ-тэй иргэдийн холбооны тэргүүн/	13:00	Мандчиглээ			13:10-13:20	Төслийн танилцуулга /Бичлэг үзэх/	Ч.Ундрахбаяр /Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвийн захирал/		13:20-18:00	Протез, ортопедийн үнэ төлбөргүй зөвлөгөө	Солонгосын DPI, Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв, сурагчид болон техникч багш нар	
Улаанбаатар хот дахь ХБ-тэй хүүхэд болон иргэдийн зорчих боломжийг нэмэгдүүлэх төсөл																																																	
Протез, ортопедийн үзэсгэлэний танилцуулга																																																	
Тайлбар	Мандчиглээ	Ганчимэг /Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дарга/	Хуан Гван Шиг /Солонгосын ХБ-тэй иргэдийн холбооны тэргүүн/																																														
13:00	Мандчиглээ																																																
13:10-13:20	Төслийн танилцуулга /Бичлэг үзэх/	Ч.Ундрахбаяр /Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвийн захирал/																																															
13:20-18:00	Протез, ортопедийн үзэсгэлэн	Солонгосын DPI, Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв, техникч багш нар																																															
Улаанбаатар хот дахь ХБ-тэй хүүхэд болон иргэдийн зорчих боломжийг нэмэгдүүлэх төсөл																																																	
Үнэ төлбөргүй зөвлөгөө өгөх танилцуулга																																																	
Тайлбар	Мандчиглээ	Ганчимэг /Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төвийн дарга/	Хуан Гван Шиг /Солонгосын ХБ-тэй иргэдийн холбооны тэргүүн/																																														
13:00	Мандчиглээ																																																
13:10-13:20	Төслийн танилцуулга /Бичлэг үзэх/	Ч.Ундрахбаяр /Түгээмэл хөгжил бие даан амьдрах төвийн захирал/																																															
13:20-18:00	Протез, ортопедийн үнэ төлбөргүй зөвлөгөө	Солонгосын DPI, Түгээмэл хөгжил бие даан амьдрах төв, сурагчид болон техникч багш нар																																															
<p>Хаана</p> <ul style="list-style-type: none"> - Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв 	<p>Хаана</p> <ul style="list-style-type: none"> - Сэргэн засалт, сургалт, үйлдвэрлэлийн төв 																																																

ЭШЛЭЛ



Өнөөдрийн байдлаар “Роснефть” компани ТС-1 гэдэг шатахуун нийлүүлж байна. Үүнийг өөр эх үүсвэрээр хангах зорилгоор судалгаа, яриа хэлэлцээ хийж байгаа. Ер нь шатахууны төлбөр МИАТ-ийн нийт зардлын 27 хувийг эзэлдэг. Тиймээс МИАТ компанийн онгоцны тийзийн үнийг бууруулах, ашигтай ажиллуулахын тулд шатахууны үнийг хямдруулах шаардлага бий. Энэ талаар ОХУ-ын Элчин сайдтай уулзах үеэрээ хэлсэн. Холбогдох хүмүүстэй уулзалт, яриа хэлэлцээ эхэлж байгаа.

ЗТХ-ийн сайд
Я.Солбаатар

Нийтлэлчийн булан

969 хүнтэй суманд спортын талбай байгуулахад 92 сая төгрөг зарцуулдаг



2098 хүн амьдардаг Дуут сумаас Ховд аймгийн төв хүртэлх 60 км шороон замыг арчлахад жил бүр 350 сая төгрөг зарцуулж байна.

◀1

Ийм байхад төсвийн дийлэнхийг орон нутаг, тэр тусмаа сумыг сөнөөчихгүйн тулд хуваарилж буйг шог гэхээс өөрөөр яаж тайлбарлах билээ. Монгол Улсын 330 сумын ихэнхийг үндэндээ оросууд л түүхий эдийн бааз сууриа бэхжүүлэхийн тулд байгуулсан. Түүнээс бус нүүдэлчдийн түүхтэй холбоотой суурин газар цөөхөн юм. Харин

Сумдын тоог цөөлж, төсвийн нурууг тэнийлгэе

жалга довны үзэлд “тархиа базуулсан” бид ЗХУ-ын үеийн хүлээсийг тайлж чадалгүй өдий хүрсэн. Одоо үүнийг залруулахгүй бол олон зуун тэрбум төгрөг үр дүнгүй зүйлд зарцуулагдаж, хөгжлийн чөдөр тушаа болсоор байна.

Хэдэн жишээ дурдахад л татвар төлөгчдийн мөнгө тойрог нэртэй УИХ-ын гишүүдийн “усалгааны талбай”, сум нэртэй хэдхэн хүний хэрэгцээнд зарцуулагдаж байгаа нь тодорхой харагдана. Тухайлбал, Завхан аймгийн Асгат гэж сум байх. Тэнд Статистикийн хорооны 2017 оны тооллогоор 969 хүн амьдарч байгаа аж. Мянга хүрэхгүй хүн амтай сумын захиргаа, сургууль, цэцэрлэг, эмнэлэгийн үйл ажиллагааг “гал алдуулахгүй” барьж байхын тулд 10 мянга гаруй оршин суугч бүхий сумтай ижил зардал гаргаж буй. Дээр нь нэмээд жилийн жилд хэрэгтэй, хэрэггүй зүйлд ч төсвийн мөнгийг цацсаар байгаа. 2019 онд дээрх Асгат суманд нийтийн спортын талбай байгуулахаар 92 сая төгрөг

төсөвлөжээ. Мөн 1397 хүнтэй Өмнөговь аймгийн Ноён суманд эмнэлгийн барилга барихаар нэг тэрбум төгрөг зарцуулахаар болсон. Үүнээс гадна төсвийн хөрөнгийг судалгаагүй зарцуулдаг байдал ч хаа сайгүй хэвшил болж эхэллээ. 1985 хүн амтай Хэнтийн Цэнхэрмандал суманд цэцэрлэгийн барилгыг 1,9 тэрбум төгрөгөөр барихаар болжээ. Гэтэл Цэнхэрмандал сумын хүн амын төрөлтийн ерөнхий коэффициент ҮСХ-ны судалгаагаар сүүлийн таван жилд огцом буурч, 17 хувьд хүрчихээд байхад шинээр цэцэрлэг барих ёстой гэсэн сэтгэлгээгээр мөнгө үрж байна.

Хүн ам багатай сумдын захиргаа, сургууль, эмнэлэг, цэцэрлэгийн шинэ барилга хийгээд урсгал зардалд энэ мэтчилэн мөнгө цацдагийг нэг бүрчлэн дүгнэвэл сонины хэдэн хуудас дүүрэхээр байна.

Монгол Улсын хэмжээнд хоёр мянга хүрэхгүй хүн амтай 45 сум байгаа бол гурван мянга хүрэхгүй хүн амтай 100 сум бий. Хүн ам

харьцангуй бага эдгээр засаг захиргааны нэгжийг тэжээхийн тулд УИХ-ын гишүүд төсвийг “хорлож” байгаа нь шударга бус. Цаад утгаараа татвар төлөгчдийг хорлож байгаа хэлбэр юм. Тиймээс гурван мянган хүнтэй суурин газарт сумын статус олгодог болчихвол 145 сум хасагдаж тэр хэрээр төсвийн хөрөнгө хэмнэгдэх боломж нээгдэхээр байгааг эрхэм түшээд эртхэн ухамсарлах хэрэгтэй.

Нөгөөтэйгүүр, эдгээр суманд зарцуулж байсан төсвийн хөрөнгийг үлдсэн 158 суманд зарцуулсан шиг зарцуулж, тохижуулсан шиг тохижуулаад үйлдвэрлэл, үйлчилгээг сайжруулчих юм бол хүссэн, хүсээгүй хасагдсан сумын иргэд татагдан очно шүү дээ. Төр өдий хүртэл зоригтой алхам хийж чадахгүй байгаагаас томоохон суурингууд хөгжлийн гацаанаас гарахгүй байна. Төр ч юу байхав улсын хөгжилд ташуур өгөх ёстой үе үеийн УИХ-ын гишүүдийн аминчхан бодол, довоо шарлуулдаг шунал чөдөр

тушаа болсоор.

Үндсэн хуулиар засаг захиргааны нэгжийн шинэ хуваарилалт хийх эрхийг УИХ-д олгосон.

● Уул уурхай хөгжиж буй Ханбогд, Цогтцэций сумын хүн ам гурав дахин нэмэгджээ.

● УИХ-ын гишүүд улсаа хөгжүүлэхийн тулд амь бие хайрлахгүй зүтгэх тангарагтай болохоос тойргоо тойглоно гэж ам гараагүй байх.

● Монгол Улсын хэмжээнд хоёр мянга хүрэхгүй хүн амтай сум 45, гурван мянга хүрэхгүй хүн амтай сум 100 байна.

УИХ-ын гишүүдийн 39 нь л үүнийг зориглоод хийчих юм бол ирээдүйд үнэлэгдэх гавьяа байгуулаа гэсэн үг. Энэ парламентад ийм боломж ч бий. Нийслэлээс сонгогдсон 28 гишүүн дээр 11 хүн иргэний зориг гаргачихвал улсын хөгжилд үнэлж баршгүй хувь нэмэр болох санж. УИХ-ын гишүүд улсаа хөгжүүлэхийн тулд амь бие хайрлахгүй зүтгэх тангарагтай болохоос биш тойргоо тойглоно гэж ам гараагүй байх. Нүдэн дээр нь сум орон нь эзгүйрч, хүн амьдрах хүсэлгүй байгааг илтгэсээр байтал өнөө маргаашийн будаг, шавраар өөрсдийгөө хуурч байгааг гишүүд мэдэрч л байгаа. Ирээдүй тэдний өмнөөс харамсаад барахгүй гэдгийг ч бас мэддэг байх.


Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн нэмэлт өөрчлөлтөөр дүүргүүдийн хүн ам өсч, аймгийн статустай болгох нөхцөл, шаардлага тулгарсан гэж үздэг. Яг үүний адил сумдыг хүн амын тоогоор нь статус тогтоож, хүрэхгүйг нь татан буулгаж яагаад

болохгүй гэж. Дургүйд хүчгүйн үлгэр л энд үйлчилж байна.

Орон нутаг дахь хүн амын шилжилт хөдөлгөөнд хийсэн судалгаагаар уул уурхай түшиглэсэн, ажлын байр бий болгосон сумдын хүн амын тоо огцом өссөн үзүүлэлт бий. Арван жилийн өмнө гурван мянга хүрэхгүй оршин суугчтай байсан Өмнөговийн Ханбогдод 6.9 мянга, Цогтцэций суманд 7.4 мянган хүн албан ёсоор бүртгүүлжээ. Түүнийг дагаад хүнс, бараа бүтээгдэхүүний жижиг, дунд үйлдвэрлэл ч эрчимтэй хөгжсөн. Энэ нь сумдын хүн ам өсөхөөр тухайн орон нутгийн өрсөлдөх чадвар нэмэгдэж байгааг тодорхой харуулж байгаа юм. Үнэхээр л бид хөгжихийг хүсч байгаа бол төсөв хөрөнгөө зөв, оновчтой зарцуулдаг болох учиртай. Суурин, баг болгоны тоогоор мөнгө төсөвлөөд байх аваас энэхүү “хөрөнгө оруулалт” ямар ч үр дүнгүй, элс рүү асгасан ус лугаа ор, мөргүй болно гэдгийг эрхэм гишүүд ойлгодог баймаар юм. [ЭН]

ЗАСГИЙН ГАЗРЫН МЭДЭЭ СОНИН

IV улирлын нэмэлт захиалга үргэлжилж байна



Онлайн захиалга

- Улиралд: 5000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 10 000₮ (124 дугаар)
- Жилд: 15 000₮ (248 дугаар)



Хэвлэмэл захиалга

- Улиралд: 30 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 60 000₮ (124 дугаар)
- Жилд: 120 000₮ (248 дугаар)



Хосолмол захиалга


(Хэвлэмэл + Онлайн)

- Улиралд: 32 000₮ (62 дугаар)
- Хагас жилд: 65 000₮ (124 дугаар)
- Жилд: 125 000₮ (248 дугаар)



QR кодыг уншуулан гүйлгээний утга хэсэгт и-мэйл хаяг, утасны дугаараа бүртгүүлэн захиалаарай.

QR код ашиглахгүйгээр төлбөр хийх бол:



2600092954

тоот дансанд мөнгөө тушаана уу.

Судлаачийн үг



НАТО-гийн альтернатив байх боломж харагдахгүй байна хэмээн Оросын эрдэмтэд онцлох нь бий

Олхонуд Баярхүү
Судлаач профессор

Америкийн гадаад бодлогын зөвлөлийн эксперт Стефен Бланкийн сонирхолтой судалгаа байна. Бүслэлтийн менталитет гэх өвчин Оросыг ороогоод байгаа ба Кремлийнхний алдаатай гадаад бодлого Оросын дотоод байдлыг бужигнуулж, оросуудын аж байдлыг доройтуулж, нийгмийн хөгжлийг нь чөдөрлөх болсон аж. Энэ бүхний буруутан нь Путин, КГБ-гээс гаралтай түүний хуучин офицеруудын бүлэг хэмээн эрдэмтэн Бланк нэрлэжээ. Тэд бол дайсагнагч капиталист хүрээлэлд бүслэгдсэн, Оросоос бусад ертөнцтэй үргэлж дайны байдал оршиж байх ёстой гэсэн сэтгэхүйтэй.

Хэрэв СССР-ийн үеийн гадаад бодлоготой харьцуулж үзвэл ОХУ-ын өнөөгийн гадаад бодлого нь түүний ойрын хөршүүдэд халгаатай. Зөвлөлт Холбоот Улс нь сайн хөршийн харилцааны концепц баримтлан найрамдал, үзэл суртлаараа холбогдож, ухаалаг дипломат бодлого явуулж байсан бол эдүгээ Кремлизэ Гүрж, Украины эсрэг явуулж буй түрэмгий бодлогын уршгаар сайн хөршийн харилцааны концепц нь алдагдаж замхарсан. Одоо Орос улс бусад хөршүүддээ хяналт тавихын төлөө л ажиллаж байна. Иймээс Орос хамгийн тааруухан хөрш хэмээн Бланк тэмдэглэжээ.



“Москва-Бээжин”-гийн шинэ блок хамтын хүчээр дэлхий дээрх үндсэн зам харилцаануудад хяналтаа тогтоох болно. Өмнө нь хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаад орхичихсон сувгийн төслүүдээ ч хэрэгжүүлж болно.

Бүслэлтийн менталитет ба Холбоотны эрэл

Нэгэнтээ эргэн тойрон дайсантай байна гэж үзвэл, тэр томъёоллоор Оросын нийгэм байнгын харанга түгшүүрийн дор, дайчилгааны байнгын бэлэн байдалд, эдийн засаг нь улам бүр милитарчлагдаж, иргэд нь сайхан амьдрахаасаа эмээж, тэр утгаар нийгэм нь огтоос хөгжилгүй болсон аж.

Стефен Бланкийн үзэл бодлыг авах гэхийн ухаанаар хүлээн авууштай. Гэхдээ анхаарах зүйл байна. Бүслэгдсэн цайзын тухай үнэт зүйлс гэдгийг тэрбээр хөнджээ. Тийм үнэт зүйлсээр хэнтэй холбогдож, хэнтэй хоршиж, хамтран ажиллах вэ. Тэр сэтгэхүй нь хувиршгүй явсаар ШХАБ-ыг залж чиглүүлэх, эгнээг нь тэлэх нэг нөхцөл болж болзошгүй. Түүнд монголчууд бэлэн үү?

Анх НАТО-г сөрөхүйц, НАТО-г бүдгэрүүлэгч их хүч байгаагаар хэмээн оросууд үзэж байснаасаа ухарсаар сүүлдээ ШХАБ-ыг Орос, Беларусь, Казахстан, Армэн, Киргизийн Гаалийн холбоо гэгчтэй холбох, олон улсын бусад байгууллагууд, юуны өмнө НҮБ-тай ШХАБ-ын хамтын ажиллагааг өргөжүүлэх болж хувиргасан нь энэ эвсэл эдүгээ ч замын бэлчирт явааг илтгэх мэт. Аль ч утгаар, томоор байг гэхэд жижгээр ч НАТО-гийн альтернатив байх боломж харагдахгүй байна хэмээн Оросын эрдэмтэд онцлох нь бий.


“ШХАБ+БРИКС=Өрнөдийн эсрэг альтернатив” гэх форматаар авч үзвэл зарим бүрдэл элемент нь харагдах авч хоршсон цэрэг-стратегийн бодлого алга, НАТО-гийн хүрч эс чадах газар очиж байлдана л гэхгүй бол өөрөөр альтернатив байх нөхцөл хараахан алга.

Яг үнэндээ бол Орост цэрэг-улс төрийн холбоотон, геостратегийн интеграц л хэрэгтэй. Тэр хүслээ ч янз бүрийн түвшинд илэрхийлдэг. “Восток-2018” хэргийн сургуулийн явцтай танилцахдаа Ерөнхийлөгч В.Путины хэлсэн үг үүний нэг жишээ нь юм. Тэрбээр “Орос бол энхийг эрхэмлэгч улс, бусад улс орнуудын талаар бидэнд түрэмгий төлөвлөгөө байхгүй. Орос нь зэвсэгт хүчнээ хөгжүүлэх ажлыг үргэлжлүүлнэ. Учир нь манай зэвсэгт хүчин улс орныхоо бүрэн эрхт байдлыг хамгаалж, манай холбоотнуудыг дэмжих чадвартай байх ёстой” хэмээн хэлжээ.

Манай холбоотнууд гэж хэнийг нэрлэв, холбоотнуудаа зэвсэгт хүчнээрээ хамгаалах гэсэн нь ямар ойлголт вэ гэдэг дээр асуудлын гол нь байна.

Хятадтай албан ёсоор тогтоосон цэрэг-улс төрийн холбоо гэж байхгүй нь мэдээж. Гэхдээ хамтарсан хэргийн

Военный союз Москва-Пекин. Перспективные участники этого альянса



сургуулиалт, хоёр улсын армийн хамтын ажиллагаа гээд авч үзвэл улс хоорондын нууц тохиролцоо байхыг үгүйсгэхгүй. Хэрэв олон улсын түвшинд Москва-Бээжингийн цэргийн блокийн тухай мэдээ тархлаа гэхэд ямар төсөөлөл буух бол.

Цэрэг-улс төрийн холбоо, блок, эвсэл альянс, ер нь ямар ч нэртэй бай түүнд оролцдог улс орнуудынхаа эрх ашгийг хамтран хамгаална гэсэн үг. Заавал цэрэг гэхгүйгээр эдийн засгийн арга хэрэгслээр ч хамгаалж болно. Зарлаагүй дайны нэг арга хэрэгсэл гэдэг утгаар. Үүнд цэргийн шинжлэх ухааны өнцгөөс Орос-Хятадын энэ талын харилцаанд хариулт эрэлхийлсэн нэгэн бүтээлээс эшлэе.

Нийтлэг үндэслэл хэд хэд байна гэж тэрхүү таамаг өгүүлэл эхэлжээ. Тухайлбал, Хятад нь Амар мөрөнд өөрийн хүссэн шаардсан газар нутгаа Оросоос эргүүлж авсныхаа дараа Номхон далай руу экспанс хийхээр анхаарал төвлөрүүлж байна. Өмнөд Хятадын тэнгист маргаантай арлууд руу тэмүүлээ. Тайванийг хүчээр нэгтгэх байр сууриа орхихгүй байна. Ийм нөхцөлд Хятад нь өөрийн хил дагуу энх тайвны бүс буй болгохыг хүснэ. Түүнд хүчирхэг эдийн засаг бүхий орнуудаас бүрдэх ШХАБ хэрэгтэй. ШХАБ-д Орос голлох үүрэгтэй. Орос ч тэр, Хятад ч тэр АНУ-ын зүгээс элдэв дайралт, өдөөн дуудалтад байнга өртөж байна. Даян дэлхийд Америкийн жанжлал гол аюулын эх сурвалж хэмээн Орос, Хятад хоёулаа үздэг. Хоёулаа нийтлэг гэхээр өнгөрсөн түүхтэй. Мэдээж СССР байхгүй бол БНХАУ гэж байхгүй байх байсан. Дэлхийн II дайны үеэр хоёуланд нь нэг дайсан

байсан ба тэр Квантуны арми бүхий Япон. Японтой хоёулаа байлдсан. Германы фашизм, Японы милитаризмыг бут цохиход СССР гол үүрэг гүйцэтгэснийг хоёул үнэлдэг. Орос, Хятад хоёул эдийн засгийн хамтын ажиллагааны асар их хэтийн төлөв, ирээдүйтэй. Умар далайн зам, Торгоны замыг холбохоор их байгалийн нөөц баялаг Сибирьт байна, тэр нь хүрэлцээтэй, Хятадыг Сибирид хангахад цаг нар гэж байхгүй. “Сила Сибири”-ийн асар их хий, хийн хөлийн бүтээн байгуулалт өрнөж байгаа.

Орост цэрэг-улс төрийн холбоотон, геостратегийн интеграц хэрэгтэй

Иймд Сибирь рүү Хятадын түрэмгийлэл үйлдэгдэх тухай сэтгэшгүй. Хятадууд “Сибирийг эзлээд дууслаа” гэдэг нь зүгээр л домог яриа, цуурхал. Орост 250 мянган хятад хүн байна, харин Дундад Азийн ард түмнүүдийн төлөөлөл саяас давдаг.

Ийм нөхцөлд ОХУ ба БНХАУ-ын холбоо байгуулбал ямар их хүчийг өөртөө төвлөрүүлэх бол хэмээн asiarussia.ru сайт баримт цуглуулан гаргаж тавьжээ. Асар их хүн ам буюу нэг тэрбум 580 сая хүн, 27 сая хавтгай дөрвөлжин гэхээр өнгөрсөн түүхтэй. Мэдээж СССР байхгүй бол БНХАУ гэж байхгүй байх байсан. Дэлхийн II дайны үеэр хоёуланд нь нэг дайсан

(нэг сая орос цэрэг, хоёр сая хятад цэрэг) гээд жагсааж болно.

Хэрэв Ази-Номхон далайн бүс нутагт нөхцөл байдал өөрчлөгддөө гэж сэтгэвэл Орос, Хятадын аль нэг арми нь нөгөөгөө халхална, хэрэв фронт аль нэгийг нь хил рүү дөхөж ирэх аваас нөгөөх нь ар талын үүрэг гүйцэтгэнэ. Холбоотон болсны дараа аль бүс нутгийг хамрах тухайд Номхон далайн хойд хэсэг, мөн Зүүн өмнөд Азид байж магадгүй гэнэ. Орос нь дорнод хэсэгтээ хуурай замын цэргээ цөөлж болно. Хятад хойд талаасаа агаараас цохилт хийлгэхээр найдвартай хамгаалагдсан байх бөгөөд хүчний харьцааг тооцвол Ази-Номхон далайн бүс нутаг ОХУ, БНХАУ-ын хяналтад аажмаар орж ирэх магадлалтай. Мэдээж Өмнөд Хятадын цэргээ цөөлж болно. Хятад хойд талаасаа агаараас цохилт хийлгэхээр найдвартай хамгаалагдсан байх бөгөөд хүчний харьцааг тооцвол Ази-Номхон далайн бүс нутаг ОХУ, БНХАУ-ын хяналтад аажмаар орж ирэх магадлалтай. Мэдээж Өмнөд Хятадын цэргээ цөөлж болно. Хятад хойд талаасаа агаараас цохилт хийлгэхээр найдвартай хамгаалагдсан байх бөгөөд хүчний харьцааг тооцвол Ази-Номхон далайн бүс нутаг ОХУ, БНХАУ-ын хяналтад аажмаар орж ирэх магадлалтай. Мэдээж Өмнөд Хятадын цэргээ цөөлж болно.

Хятад улс эдийн засгийн, Орос нь цэргийн шугамаар манай гаригт нөлөөгөө тэлж болно. Хэрэв холбоотны харилцаа тогточихвол АНУ Хятад руу халдаж дайрах нь ар талын үүрэг гүйцэтгэнэ. Хятадын талд зогсож, тэдний флот Хятадынхтай нэгдвэл хэнд ч хүчрэгдэхгүй болох гэнэ.

Хятад улс эдийн засгийн, Орос нь цэргийн шугамаар манай гаригт нөлөөгөө тэлж болно. Хэрэв холбоотны харилцаа тогточихвол АНУ Хятад руу халдаж дайрах нь ар талын үүрэг гүйцэтгэнэ. Хятадын талд зогсож, тэдний флот Хятадынхтай нэгдвэл хэнд ч хүчрэгдэхгүй болох гэнэ.

Лаос, Камбож, Мьянмар гэхчлэн. Энд Монголыг нэрлээгүй нь анхаарал татна. Оросын цэрэг-стратегийн судлаачид Монголд итгэлгүй ханддаг нь энэ юм болов уу, эсвэл хэрэгссэнгүй юу.

Орос, Хятадын цэргийн эвсэл холбоонд Энэтхэг нэгдэж орохыг үгүйсгэхгүй. Энэтхэг болон Хятадын харилцаа “сайнгүй” гэж үздэг ч Грек, Турк хоёроор жишээлж болно. Тэр хоёр улс байнгын дайны байдал байдаг ч НАТО-д зэрэгцэн гишүүнчлэгдэж, нэгдсэн зорилгоо шийдвэрлэхэд нь саад болоогүй байна. Тэгвэл Энэтхэг, Хятад ойртох алхмаа байнга хийж байна. ОДКБ эвслийн бүх гишүүн улс Орос, Хятадын тийм альянсд орох магадлал нэн өндөр. Барг тэгэх ч биз. Белорусс, Казахстан улс эхний ээлжинд элсэх аж.

Ингээд эвсэл болоод авбал манай гаригийн тэвэрийн сүлжээ урсгалуудыг дахин хуваарилах хэрэг тохионо. Тэвэрийн зам харилцаанд хяналтаа тавих нь Америкийн зэвсэгт хүчний үндсэн зорилт. Тэгвэл “Москва-Бээжин”-гийн шинэ блок хамтын хүчээр дэлхий дээрх үндсэн зам харилцаануудад хяналтаа тогтоох болно. Өмнө нь хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаад орхичихсон сувгийн төслүүдээ ч хэрэгжүүлж болно. Тайланд, Никарагуагийн нутаг дэвсгэрээр дамжсан Панамын суваг маягтай сувгуудыг нэрлэж болно.

Дараагийн шатанд Хятад нь сувгуудаа байгуулах ба Оросын цэргийн бааз түүнийг нь хамгаална. АНУ-ын өмнөд жигүүрт хүрч ажиллана. Ойрхи Дорнод, Магриб хавьд Орос, Хятадад муугүй хэтийн төлөв харагдаж байна. Орос цэргийн бааза Сирид байгуулаад авлаа, Судан, Ливид байгуулж болно. Хятадын бааз Жибутид байж байна. Ийм зураглал дэлхийн бусад бүс нутгуудад мөн хамаарна.

Энэхүү сэдвийг өргөн уншигчдад хүргэж, хэлэлцүүлэг өрнүүлэх хэрэгтэй хэмээн asiarussia.ru сайтад бичээд хэрэв ОХУ, БНХАУ хамтарч цэргийн альянс байгуулбал өрнөдийнхөнд хохиролтойгоор хүчний тэнцвэр өөрчлөгдөнө, Хятад, Орос, Энэтхэг, Иран, Хойд Солонгос, мөн ОДКБ эвслийн орнуудын армиуд нь НАТО, Япон, Өмнөд Солонгос, Австралийн армиас хавьгүй давах болно гэжээ.

Зохиогч миний зүгээс үүнд нэмж хэлэх тайлбар алга. Оросын чин хүслийн илэрхийлэл болсон тохиолдлын ганц мэдээлэл юм. Гэхдээ иймэрхүү агуулга бүхий мэдээлэл, төсөөлөл, таамаглал Оросын элдэв сайтуудад тоймгүй олон тавигдаж гэдгийг нэмж хэлэх байна.

[ЗГМ СӨНИН]

“Засгийн газрын мэдээ” сонин нь ардчилсан, шударга ёс, хүний эрхийг дээдэлж, чөлөөт сэтгүүл зүйн хэмжээг бүрнээ сахин, олон ургальч үзлийг илэрхийлэх мэдээллийн индэр байж, нийт Монгол үндэстний ойлголцол, эв нэгдлийг бэхжүүлэхийг эрхэм зорилго болгоно.

ТУЗ-ийн дарга
Эрдэнэбаатар ДӨЛГИОН
Утас: 99901621

Ерөнхий эрхлэгч
Баатарын ДУЛАМХОРЛОО

Зөвлөх
Шатарбалын ДАВААДОРЖ

Орлогч эрхлэгч
Лягважавын СУГАРМАА
Утас: 99903584

РЕДАКЦ

Улс төр, нийгэм, эрэн сурвалжлах мэдээллийн алба
Эдитор Б.Энхжаргал
Утас: 99901621

Цахим контент, бүтээлч үйлдвэрлэлийн алба
Эдитор Г.Баарсайхан
Утас: 99903574

Эдийн засаг, уул уурхайн мэдээллийн алба

ЗАР СУРТАЛЧИЛГАА

Утас: 99903581
99903578
99907843

ХАЯГ

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
I хороо, Энхтайвны өргөн чөлөө,
“Бло Скай таур” 407 тоот
Улсын бүртгэлийн дугаар. 1024
Утас: 70103131,
Факс: 7010606

ЦАХИМ ХУВИЛБАР

zgm.mn
ubinfo.mn
Дугаарын удирдагч
Л.Сугармаа

ЗГМ: Сэдэв

Монголд хоёр хүн тутмын нэг нь ажилдаа сэтгэл ханамжгүй, солих хүсэлтэй байна

З.Цэлмэг
@tselmegZGM

АНУ-ын супермаркетын сүлжээ болох 38 жилийн түүхтэй Whole foods market-ийг үүсгэн байгуулагчийн нэг Жон Майей хэдэн жилийн өмнө Уол Стрийтэд хийсэн бизнес аяллаасаа АНУ-ын хамгийн амжилттай компаниудын нууцыг олж мэдсэн гэдэг. Түүний олж харснаар ажилчиддаа анхаардаг болон анхаардаггүй компаниуд хоорондоо хөгжил дэвшлээрээ



С.Батсайхан / ЗГМ©


хөдөлгөөн ч хүнд тусдаг. Гэтэл 2000 хүнтэй компани 50-100 хүн орж гарсан ч бүтээгдэхүүний чанар, үйлчилгээнд нөлөөлөхгүй. Манайд гэхэд жилд 200 эмэгтэй жирэмсний амралт авдаг” гэсэн юм. Тиймээс ЖДУ-ийн салбарын хүний нөөцийг анхаарах шаардлагатайг тэрбээр онцоллоо. Хүний нөөцийн мэргэшсэн NPC&Mandal компанийн хийсэн судалгаагаар монгол хүний ажлын бүтээмж дэлхийн дунджаас 25 хувь доогуур байдаг байна. Уг нь монгол хүн аливааг маш хурдан сурдгийг япончууд судалж мэджээ. Япон хэлийг сурахад бусад орны иргэд дунджаар 1500 цаг заалгадаг бол монголчуудад 1200 цаг хангалттай байдаг аж.

Хүний нөөцийн “Могоул консалтинг” компани энэ хавар 500 хүнд хийхэд судалгаагаар хоёр ажилтан тутмын нэг нь ажилдаа сэтгэл хангалуун

Хүн төвтэй бизнесийн хаанчлал айсуу

эрс ялгаатай байжээ. Тэрбээр “Хүчирхэг, ухаалаг, эрүүл тогтолцоотой байгууллага ажилчиддаа өөрсдийнх нь үнэ цэнийг мэдрүүлдэг, ажил, үүргийн хуваарийг нь маш тодорхой гаргаж өгсөн байдаг” хэмээн хожим дурссан юм. Бизнесийн өршөөлгүй өрсөлдөөн хамгийн эртэй өрнөдөг Уол Стрийтээс эргэж ирээд Жон Майей компани байгуулахдаа дөрвөн зүйлд онцгойлон анхаарсан аж. Компани өрсөлдөөнийг саадгүй давдаг болгохын тулд тэрбээр ажилчиддаа өсөн дэвжих боломж олгож, бүтээмжийг нь нэмэгдүүлж, асуудлыг оновчтой, шинэлэг байдлаар шийдвэрлэдэг нэг үгээр бол, хүн төвтэй соёл төлөвшүүлжээ. Үүний үр дүнд өдгөө Whole foods market нь АНУ, Их Британи, Канадад 479 салбартай, 91 мянга давсан ажилчинтай, дэлхийн хэрэглэгчдийн хамгийн их үйлчлүүлдэг газар болжээ.

“Компанийн өсөж дэвжих суурь болсон хүнээ анхаарснаар бүтээгдэхүүн, үйлчилгээ нь зах зээлд өндөр үнэлэгдэж байвал тухайн байгууллагын хүний нөөцийн бодлого зөв чиглэж байгаа гэсэн үг” хэмээн Монголын хүний нөөцийн судалгааны үндэсний хүрээлэнгийн захирал Г.Тэгшбүрэн хэлж байна. Өөрөөр хэлбэл, та ажилчиддаа санаа тавьбал ажилчид таны бизнест санаа тавина. Дэлхийн хамгийн алдартай технологийн компаниудын хүний нөөцийн бодлогыг нутагшуулж яваа New Media Group-ийн онцолж буйгаар ажилтан гэдэг байгууллагын хөрөнгө, өндөр байшин, гоё компьютерээс үнэ цэнтэй баялаг гэдгийг ойлгож, энэхүү баялгаа



судалж, сургаж хөгжүүлж, арчлан, авьяас чадварыг нь нээх, боломж олговол байгууллагыг хөгжилд хөтлөх шидтэн хэмээдэг аж. Харамсалтай нь, Монголд компаниуд ашиг орлогоос илүү хүндээ анхаарах төлөвшил дутагдаж буй ШУА-ийн академич Т.Болд шүүмжилж байна.

АЖИЛ, АМЬДРАЛЫН НЭГДЭЛ БҮТЭЭМЖ ӨСГӨДӨГ


Гэртээ байгаа мэт тохижилттой оффис, ажлын цагийг зургаа болгож багасгасан шийдвэр зэрэг нь яг үнэндээ ирээдүйд улам эрчээ авах чиг хандлага боллоо. Яагаад гэвэл, өдгөө хөдөлмөрийн зах зээлийг жолоодож байгаа нь 1980-2000 оны хооронд төрөгсөд буюу Y үеийнхэн. Тэд гэртээ ирээд ажил ярих ёсгүй гэж үздэг өмнөх үеийнхнээс эрс ялгаатай. Харин ч ажил, амьдралын зааг ялгаа багасаж, ойртон нэгдэх тусам бүтээмж нь дээшилж буйг финтек компаниуд үлгэрлэж буй. Ажилчид кофе уухдаа, фитнес эвсэл явахдаа, компьютер эсвэл ямар нэг спорт тоглоом хоорондоо тоглохдоо ажлаа тасралтгүй ярилцах нь ажлын бүтээмжийг нэмэгдүүлдэг байна. Хөдөлмөрийн зах зээлд

ноёлогчдын 60 хувь нь ажил, амьдралын нэгдлийг илүүд үзэж буйг Хүний нөөцийн судалгааны үндэсний хүрээлэнгээс судалж тогтоожээ.

New Media Group-ийн Маркетингийн газрын захирал Т.Төгөлдөр “Хүн хүссэн цагтаа ажилласнаар сайн гүйцэтгэлтэй байдгийг шинжлэх ухаан тогтоосон. Тухайн хүн ажлаа хийх явцдаа дурладаг зүйлдээ ойрхон байвал бүтээмж нь дээшилнэ. Тэр нь компьютер тоглоом, спорт, магадгүй амттан гээд юу ч байж болно” гэв. Хүний нөөцийн мэргэжилтнүүдийн хийсэн судалгаагаар амттан худалдаж авахад зарцуулсан 5000 төгрөг ажлын бүтээмжийг 20 хувь нэмэгдүүлдэг аж.

ЖДУ-ИЙН САЛБАРТ ХҮНИЙ НӨӨЦИЙН МЕНЕЖМЕНТ МУУ БАЙНА

2017 оны байдлаар бизнес регистрийн санд бүртгэлтэй 126.5 мянган аж ахуйн нэгжийн 50 гаруй хувь нь үйл ажиллагаа идэвхтэй явуулж буй. Үүнээс 51917 нь жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарт хамаарч буй бөгөөд нийт ажиллах хүчний 67 хувийг эзэлдэг байна. Гэтэл



улсын хэмжээнд хэрэгжиж буй хүний нөөцийн бодлого, мэргэжлийн программ, зовлон жаргалаа ярилцдаг талбарт том компани, төрийн байгууллагууд идэвхтэй оролцдог. Тиймээс хөдөлмөрийн насны 1.2 сая орчим хүний 720 гаруй мянга нь хүний нөөцийн бодлогоос гадуур

байдаг гэсэн үг. Цаашлаад жижиг дунд үйлдвэрлэлд хүний нөөцийн орох, гарах урсгал их байх нь өсөлт хөгжилд нь саад болдог аж. Энэ нь зөвхөн үйлдвэрлэлийн салбарт бус байгууллагуудад учруулдаг гэнэ. Голомт банкны ерөнхийлөгч Г.Ганболд “10-20 хүнтэй компанид нэг хүний

бус, ажлын байраа солих хүсэлтэйгээ илэрхийлсэн байна. Тэд энэ шийдвэрийг гаргахдаа өсөн дэвжих боломж, цалин хангамж болон сурч хөгжих орчинд үндэслэсэн байна. Гэтэл аж үйлдвэр өндөр хөгжсөн орнуудад зургаан хүн тутмын нэг нь ажилдаа сэтгэл ханамж муутай байдаг аж.

Эдийн засгийн макро үзүүлэлтүүд компаниудын хувьд хүндээ хөрөнгө оруулах цаг болсныг илтгэж буйг МУХАУТ-ийн ерөнхийлөгч Б.Лхагважав онцоллоо. Тэрбээр “Эдийн засаг өсөж буй энэ үед компаниудад хамгийн хэрэгтэй байдаг гурван зүйлийн нэг нь чадварлаг боловсон хүчин. Хүний нөөцдөө хөрөнгө оруулж чадсан компаниудад л эдийн засгийн өсөлт бодитой нөлөөлнө” хэмээсэн юм. [ЗГМ]

ЭРХЭС ПЛАТФОРМ ЦАХИУРЫН ХӨНДИЙД НЭЭГДЛЭЭ

“ЭРХЭС” маркетинг, борлуулалтын нээлттэй эхийн платформ Монголын старт-апуудыг түүчээлэн АНУ, Сан Франциско дахь Цахиурын Хөндийн “Product Hunt” платформ дээр нээлтээ хийв.

Хэдхэн сарын өмнө Цахиурын хөндийг зорьж, гарааны бизнесийн ачуулууд дунд туршлага судлан, бүтээгдэхүүн хөгжүүлэлтээ сайжруулж, олон улсын түвшинд өрсөлдөхөөр явсан “ЭРХЭС” платформын баг хамт олон зорилгодоо хүрэх дараагийн алхмаа хийхэд бэлэн болсон байна.

“ЭРХЭС” нь хэрэглэгчтэй харилцах сувгуудыг нэгтгэн удирдаж, маркетинг борлуулалтын шийдэл санал болгодоороо гадны платформуудтай эн зэрэгцээд зогсохгүй функц, ажиллагаа, байгууллагын онцлогт нийцсэн нэмэлт хөгжүүлэлт хийх боломжуудаараа хэрэглэгчдийнхээ хэрэгцээ шаардлага, үйл ажиллагаанд илүү нийцсэн шийдлийг дотоодын болон олон улсын зах зээлд санал болгож байна.

Олон улсын зах зээлд гарахыг зорьсон старт-апууд бүтээгдэхүүний нээлтээ Product Hunt платформ дээр зарлан, олон нийтэд таниулж, хэрэглэгчийнхээ хүрээг тэлэх нь орчин үеийн гарааны бизнесүүдийн олон улсад амжилттай байрших эхний үйлдэл гэж хэлэхэд хэлсэдэхгүй. Энэ жишгийн дагуу “ЭРХЭС” платформ маань Цахиурын Хөндийн Product Hunt платформ дээр олон улс дахь нээлтээ Улаанбаатарын цагаар 2018 оны 10 сарын 15-ны өдрийн 15:00 цагт зарлаж, тус платформ дээр 24 цагийн турш байршин, санал, үнэлгээгээрээ бусад бүтээгдэхүүнтэй өрсөлдөх юм.

Монголын старт-апуудын хувьд онцгойд тооцогдох энэхүү үйл явдлыг тохиолдуулан HUB Innovation Center “Амжилтын Хонх”-оо цохих баярын өдөрлөгийг зохион байгуулах гэж байна. Уг хонхыг старт-апын экосистемд тохиосон онцгой амжилт, түүхэн үйл явдлуудын гэрч болгон цохиж, баяр хүргэн урам зоригоор тэтгэх зорилготойгоор хэрэглэх бөгөөд хамгийн анхны хонхны эзэнээр “ЭРХЭС” нээлттэй эхийн платформ тодорлоо.

Монгол инженерүүдийн бүтээсэн “ЭРХЭС” платформыг дэлхий нийтэд таниулахад хэн бүхний оролцоо чухал тул та уг платформыг дэмжихийг хүсвэл <https://www.producthunt.com/posts/erxes-inc> холбоосоор орж ERXES бүтээгдэхүүнд саналаа өгөөрэй.

Дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл бидэнтэй холбоо барина уу.

**Хаяг: Нийслэлийн Улаанбаатар Чуулгын барилгатай залгаа HUB
Инновацийн Төв 1 тоот, Бээжингийн гудамж, 8-р хороо, СБД
Холбоо барих утас: 365555; 99079070
И-мэйл хаяг: info@erxes.io
Вэб сайт: www.erxes.io**

БАЙР СУУРЬ

**АЖИЛ ОЛГОГЧИД БИШ
ГОРИЛОГЧИД ШААРДЛАГА
ТАВЬДАГ БОЛСОН**



“Могоул консалтинг”
компанийн гүйцэтгэх захирал
Н.Жавхлан

–Монголд хүссэн8 хүсээгүй компаниуд ажилчдынхаа нийгмийн асуудлыг шийдсэн, хүн төвтэй болохоос аргагүй болж байна. Өмнө нь байгууллагууд нээлттэй ажлын байр зарлахад л хүмүүс анкет бөглөөд, хэдэн арваараа очдог байлаа. Одоо бол ажил олгогчдод ажил горилогчид шаардлага тавьж, сонгодог болсон байна.

Гэхдээ бодит байдалд компаниуд хүн төвтэй бодлого хэрэгжүүлж чадаж байгаа эсэхэд нь би эргэлздэг. Яагаад гэвэл, шинэ үеийнхнээ ойлгохгүй, тэдэнд чиглэсэн бодлого хэрэгжүүлж чадахгүй бол шинэ үеийнхэн ажиллахгүй. Ямар ч байгууллага ажилтангүйгээр явахгүй шүү дээ.

**МОНГОЛ УЛС
АНГУУЧИЛДЫН ТАЛБАР
БОЛСОН**



Голомт банкны ерөнхийлөгч
Г.Ганболд

Монголд “Talent hunting” буюу авьяаслаг ажилчдыг ангуучлах ажил хэдийн эхэлсэн. Ялангуяа, мэдээлэл технологийн салбарт АНУ-д төвтэй хоёр их сургуулийн салбар 4-5 жилийн өмнөөс орж ирсэн. Банкууд, үүрэн холбооны оператор компаниудын мэдээлэл технологийн мэргэжилтнүүдээ тэдэнд алдаж эхэлсэн. Тэд Монгол компаниудын хувьд хөдөлмөрийн зах зээл дээр өрсөлдөхөд хүнд нөхцөл амлаад боловсон хүчнийг нь аваад явдаг. Авьяаслаг ажилчид байгууллагад нийт ажилчдын магадгүй 5-6 хувийг эзлэх ч ашигт ажиллагааг нь хангахад 80-90 хувийн хөшүүрэг болдог. Тиймээс тэднийг авч үлдэх, хөгжүүлэх гээд авьяасын менежментэд анхаарах цаг болсон.

**АЖИЛЧИД БОЛ
БАЙГУУЛЛАГЫН
БИЗНЕСИЙН ТҮНШ**



Хүний нөөцийн судалгааны
үндэсний хүрээлэнгийн захирал
Г.Тэгшбүрэн

Хүний нөөцийн удирдлага бол байгууллагын бизнесийн түншийн зарчмаар явдаг. Өөрөөр хэлбэл, байгууллагын бизнес хүн дээр суурилж хөгждөг гэдгийг удирдлага ойлгож, хүн төвтэй байхад онцгойлон анхаарах ёстой.

Монголд бизнесийн байгууллагууд том, жижиг гэлтгүй бүгд л хүний нөөцийн бодлогодоо хүн төвтэй томьёолол баримталж байгаа. Гэхдээ хэрэгжүүлж чадах эсэх нь цаг хугацаанаас хамаардаг. Сайн компаниуд 1-2 жилд хэрэгжүүлж байгаа бол чадавх муутай нь 5-6 жилээс наашгүй. Гэхдээ зөв зүгтээ явж буй тул хэзээ нэгэн цагт хүрэх л байх, тэр цагт хөгжиж эхэлнэ гэсэн үг.

ЗГМ: Зочин

Хуулийн дагуу ажиллаж байхад хэн ч дарамт үзүүлж чадахгүй байх

Цагдаагийн мөрдөгч болно гэж бодож байгаагүй

Мөн гэмт хэргийн бодлого бодуулж, төлөвлөгөө боловсруулна.

Би 2016 онд анх орсон ч амжилт үзүүлж чадаагүй. Харин энэ жил хууль эрх зүйн мэдлэгийн сорилууд дээр өндөр оноо авсан нь түрүүлэх гол шалтгаан болсон. Мөрдөн байцаах алба 2018 оны гуравдугаар сараас эхлэн нийт мөрдөгч нараас хууль эрх зүйн мэдлэгийн шалгалтыг сар бүр авдаг болсон юм. Эдгээр шалгалт өөрийгөө сайжруулахад хамгийн гол нөлөө үзүүлсэн болов уу.

-Мөрдөгчөөр ажиллаад хэр удаж байна вэ. Ер нь яагаад энэ мэргэжлийг сонгох болов?

-Миний хувьд цагдаагийн мөрдөгч болно гэж бодож байгаагүй. Арван жилээ төгссөний дараа хэд хэдэн сургуульд конкурс өгч байгаад 2010 онд Цагдаагийн академид элсэн орсон юм. Манай хамаатан садны дунд цагдаагийн байгууллагад ажилладаг хүн байхгүй. Тиймээс энэ ажлын талаарх ойлголт төдийлэн сайн байгаагүй. Цагдаагийн сургуульд суралцсан дөрвөн жилийн хугацаанд багагүй зүйлийг мэдэж авсан. Мөн дадлага хийх явцдаа цагдаагийн алба гэж юу юм, ямар зарчмаар ажилладаг вэ гэсэн тодорхой мэдлэгтэй болсон л доо.

2014 онд сургуулиа төгсөөд эрх зүйч мэргэжлээр бакалаврын диплом болон цагдаагийн дэслэгч цолоо гардан авч Чингэлтэй дүүргийн цагдаагийн 1 дүгээр хэлтэст мөрдөн байцаагчаар томилогдон ажиллаж эхэлсэн юм. Харин энэ оны гуравдугаар сараас Мөрдөн байцаах албаны Хүнд гэмт хэрэг мөрдөн шалгах хэлтэст ахлах мөрдөгчөөр томилогдон ажиллаж байна.

Ер нь сургууль болгон төгсөх курстээ уртын дадлага хийдэг дээ. Энэ үед эрүүгийн цагдаагийн алба болон мөрдөн байцаах албаны алба хаагч нарын удирдлаганд уртын дадлага хийсэн. Тэр үеэс л мөрдөн байцаагч болохоор шийдсэн юм.

-Дөнгөж төгсөөд ажлын байран дээр ороод ирлээ. Анх хэрэг даалгах үед мэдэхгүй, чадахгүй зүйл тохиолдож байв уу?

-Бид ЦЕГ-ын даргын тушаалаар томилогдож, цолоо аваад албан тушаал дээр очиж байгаа хүмүүс. Анх өмчлөх эрхийн эсрэг гэмт хэрэг, хүний эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэргүүд шалгаж эхэлсэн. Дөнгөж төгссөн учраас мэдэхгүй чадахгүй зүйл мэдээж гарна. Тиймээс бидэнд дадлага удирдагч сурган зааварлагч багш томилогдож юм. Тухайн үед цагдаагийн ахмад Ч.Ганзориг миний багшаар томилогдож, би өөрийн хариуцаж буй хэрэг болгоныг хянуулж, зөвлөгөө авдаг байв.

-Энэ ажлыг хийж чадахгүй нь гэж шантрах үе байв уу?

-Шинэ албанд томилогдоод хэдэн сар ажиллахад хэргийн ачаалал ихсэж байсан энэ үед л шантарч байсан. Харин яваандаа ажилдаа зүгшрээд ажлын ачаалал дааж сурсан л даа.

-Мөрдөгчийн ажлын ачаалал хэр байна вэ. Нэг мөрдөгч ойролцоогоор хэдэн хэрэг хариуцаж байгаа бол?

-Ер нь мөрдөгч нарын ажлын ачаалал их байдаг.

-Мөрдөгчөөр ажиллаад дөрвөн жил болжээ. Хэрэг мөрдөн шалгах явцад тохиолдсон сонирхолтой, адармаатай явдлаас жишээ болгон ярьж болох уу?



С.Батсайхан / ЗГМ©

-Ямар ч хэргийг шалгахдаа үнэнийг нь заавал олж тогтоохын төлөө ажилладаг. Нэг хэргийн араас орж, шалгаад явж байхад бүх зүйл үнэн бодитоороо гарч, зөв зүйтэй шийдэгдэхийг харах сайхан байдаг юм.

-Энэ дундаас санаанд тод, нэлээд удаан ноцолдож байж учрыг нь олсон хэргээс дурдвал?

-Чингэлтэй дүүрэг дэх Цагдаагийн 1 дүгээр хэлтэст ажиллаж байхдаа өмчлөх эрхийн эсрэг хэд хэдэн гэмт хэргийг нэлээн удаан хугацаанд шалгаж шийдвэрлэж шүүхээр эцэслэн шийдвэрлүүлж байсан даа. Хэргийн нарийн ширинийг хамаагүй ярьж болохгүй байх.

-Манай мөрдөгчид хуучин социализмын үеийн арга барилаасаа одоо болтол салаагүй гэж шүүмжилдэг. Өөрөө залуу үеийн төлөөлөл болон ажиллаж байгаа хүний хувьд үүнд ямар тайлбар өгөх вэ?

-Манай мөрдөгчид хууль заасан эрх үүргийнхээ хэмжээнд ажиллаж байгаа гэж боддог. **-Гэр бүлтэй болж амжсан уу. Ер нь мөрдөгчийн гэр бүлийн амьдрал ямархуу байдаг бол?**

-Би эхнэр, хүүхэд, ээжтэйгээ амьдардаг. Сургуулиа төгссөний дараа эхний хоёр жил ёстой л цаг наргүй ажилладаг байлаа. Сүүлдээ дадлага туршлага хуримтлуулаад ирэхээр ажлаа хурдан хийж, гэрийнхэндээ цаг зав гаргах боломж бүрдсэн.

-Хууль эрх зүйн мэдлэгийн сорилууд дээр өндөр оноо авсан нь шилдэг мөрдөгч шалгаруулах тэмцээнд түрүүлэх гол шалтгаан болсон.

-Бүх зүйл үнэн бодитоороо гарч, зөв зүйтэй шийдэгдэхийг харах сайхан байдаг.

-Цалин хүрэлцэх, эсэх нь хүн бүрийн хэрэглээнээс хамаарах байх.

-Мөрдөн байцаагчид хэргийг шийдэхгүй хэтэрхий удааж байна гэсэн шүүмжлэл иргэдийн дунд байдаг. Энэ юутай холбоотой бол?

-Янз бүрийн л шалтгаан байдаг байх. Мэдээж ажлын ачаалал хамгийн гол шалтгаан. Тиймээс зарим нэг хүний хэргийг шийдэлгүй удаашруулах тохиолдол гардаг л байх. Нөгөөтэйгүүр мөрдөгчийн ур чадвар нөлөөлдөг болов уу. Тогтоосон хугацаанд хуулийн дагуу шийдвэрлээд өгвөл хэл ам

гаргахгүй шүү дээ.

-Манай мөрдөгчид хуучин социализмын үеийн арга барилаасаа одоо болтол салаагүй гэж шүүмжилдэг. Өөрөө залуу үеийн төлөөлөл болон ажиллаж байгаа хүний хувьд үүнд ямар тайлбар өгөх вэ?

-Манай мөрдөгчид хууль заасан эрх үүргийнхээ хэмжээнд ажиллаж байгаа гэж боддог.

-Гэр бүлтэй болж амжсан уу. Ер нь мөрдөгчийн гэр бүлийн амьдрал ямархуу байдаг бол?

-Би эхнэр, хүүхэд, ээжтэйгээ амьдардаг. Сургуулиа төгссөний дараа эхний хоёр жил ёстой л цаг наргүй ажилладаг байлаа. Сүүлдээ дадлага туршлага хуримтлуулаад ирэхээр ажлаа хурдан хийж, гэрийнхэндээ цаг зав гаргах боломж бүрдсэн. Ажлаа зөв төлөвлөж, хийх ёстой юмаа цаг тухайд нь хийгээд явбал өдөржин шөнөжин гүйгээд байх шаардлагагүй шүү дээ. Хувь хүнээс л шалтгаалж байгаа юм. Манай эхнэр, гэр бүлийнхэн маань миний ажлыг маш сайн ойлгож, дэмждэг юм.

-Ганц төлөг хүлгэйлсэн хүн торны цаана олон жил сууж байхад олон тэрбумын хэрэгтэй нохдүүд хөнгөн ял аваад байна гэх яриа бий. Мэдээж хэрэг болгон мөрдөн байцаагчийн гараар дамжиж байгаа. Хууль тэгш үйлчлэх заалт хаанаа гажуудаад байна вэ?

-Бидний зүгээс мөрдөн байцаалтын явцад яллах болон цагаатгах талын бүхий л нотлох баримтыг цуглуулж, бэхжүүлж, хэргийг тал бүрээс шуурхай, бодитой шалгаж прокурорт шилжүүлнэ. Үүнийг прокурор хүлээн авч хянаад гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдсон байна гэж үзвэл шүүхэд шилжүүлдэг. Шүүхээс хууль заасны дагуу шүүх хурлыг товлож хавтас шалгаж, гэмт хэрэг мөн, бишийг нь тогтоогоод шилжүүлдэг. Үүнээс цааш юу болдог, хэн нь буруутай вэ гэдэг дээр миний зүгээс үнэлэлт дүгнэлт өгөхөд хэцүү л дээ.

-Авлига хээл хахууль, албан тушаалын хэргийг шалгахад дээрээс дарамт шахалт ирдэг гэж ярьдаг. Өөрт чинь ийм зүйл тохиолдож байв уу?

-Надад бол айтхар дарамт ирж байгаагүй. Яг л хуулийнхаа дагуу ажиллаж байгаа

тохиолдолд ямар ч хүн дарамт шахалт үзүүлж чадахгүй байх гэж боддог.

-Өөр шиг чинь ийм бодолтой мөрдөгч аль болох олон байгаасай гэж хүсэж байна.

-Баярлалаа.

-Цагдаагийн алба хаагчид

авлигад өртөхгүйн тулд цалин хангамж, ноцол нь сайн байх ёстой. Харин өөрийн чинь хувьд хөрөнгө мөнгөний тал дээр бусдаас хараат болохгүй, өөрийн цалингаар гэр бүлээ асуудалгүй аваад явчих боломж байна уу?

-Цалин хүрэлцэх, эсэх нь хүн бүрийн хэрэглээнээс хамаарах байх. Миний хувьд гэр бүлээ тэжээгээд явчих хэмжээний цалин авдаг гэж боддог. Ажилласан жил, авсан цолноосоо шалтгаалаад цалин хөлс цаашид нэмэгдэх байх. [ЗГМ]

“ДИ БИ ЭМ ЛИЗИНГ” ХХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮДИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫГ ДАХИН ЗАРЛАЖ БАЙНА

Монгол Улсын Хөгжлийн банкны охин компани болох “Ди Би Эм лизинг” ХХК нь 2017 оны 06 дугаар сарын 16-ны өдөр үүсгэн байгуулагдаж, Санхүүгийн түрээс буюу лизингийн үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна. “Ди Би Эм лизинг” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2018 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн хурлаар компанийн засаглалын хэлбэрээ өөрчилж, Төлөөлөн удирдах зөвлөлтэй байхаар шийдвэрлэсэн тул компанийн тухай хууль, компанийн дүрэм, “Ди Би Эм лизинг” ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын ХЭХ-26 тоот шийдвэрийг тус тус үндэслэн “Ди Би Эм лизинг” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүний сонгон шалгаруулалтыг 9 дүгээр сарын 26-ны өдөр зарласан.

“Ди Би Эм лизинг” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтад оролцогчид онооны нийлбэр дүнгээр авах ёстой оноонд хүрээгүй тул сонгон шалгаруулалтыг дахин зарлаж байна.

1. Зээл, баталгаа, батлан даалтын гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй байх;
2. Банк, санхүү, эрх зүй, инженер, эдийн засгийн дээд боловсролтой, тухайн салбарт удирдах албан тушаалтнаар таваас доошгүй жил ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх;
3. Ял шийтгэлгүй байх;
4. Төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх, сүүлийн таван жилд улс төрийн албан тушаал хашиж байгаагүй байх;
5. Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй болох нь нотлогдсон байх;
6. Монгол Улсын Хөгжлийн банкаас бусад банкны салбарын байгууллагын эрх бүхий албан тушаалтан бус байх;
7. Зөрчлийн улмаас банк, банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед тухайн байгууллагын эрх бүхий албан тушаалтан байгаагүй байх;
8. Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ захиргааны хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх.
9. Компанийн засаглалын сургалтад хамрагдсан байх.
10. Компанийн тухай хуулийн 79.1-т заасан шаардлагууд.

БҮРДҮҮЛЭХ МАТЕРИАЛ:

1. Төрийн албан хаагчийн анкет, Нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн этгээдийн хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, гурван үеийн намтар;
2. Иргэний үнэмлэхийн хуулбар; Цээж зураг 4х6 см хэмжээтэй 2 хувь;
3. Боловсролын диплом, үнэмлэх, гэрчилгээний нотариатаар гэрчлүүлсэн хуулбар;
4. Нийгмийн даатгалын дэвтрийн нотариатаар гэрчлүүлсэн хуулбар, ТҮЦ машины лавлагаа /сүүлийн 2015-2018 оны байдлаар/;
5. Сонгон шалгаруулалтад оролцохыг хүссэн өргөдөл;
6. Оршин суугаа газрын тодорхойлолт/ ТҮЦ машины лавлагаа/;
7. Иргэний ял шийтгэлтэй эсэх талаарх цагдаагийн газрын тодорхойлолт;
8. Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалсан эсэх тухай” эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан хуулийн этгээдийн лавлагааг УБЕГ-аас, ШШГЕГ-аас тус хуулийн этгээд дампуурсан эсхүл өр төлбөргүй эсэх лавлагаа;
9. “Зөрчлийн улмаас банкны тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан эсэх талаарх” Санхүүгийн зохицуулах хорооны тодорхойлолт.
10. Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж байсан гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар.

СОНГОН ШАЛГАРУУЛАЛТЫН МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХАЯГ:

Монгол улс, Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 15-р хороо, Энхтайвны өргөн чөлөө, “EAST PLAZA” 39-р байр 5 давхар, утас: 77307070, “Ди Би Эм лизинг” ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүдийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах Түр хорооны Нарийн бичгийн дарга Ж.Алтантуяа / Утас: 99051914 Цахим хаяг: altantuya.j@dbmleasing.mn/

МАТЕРИАЛ ХҮЛЭЭН АВАХ ХУГАЦАА:

Сонгон шалгаруулалтад оролцох иргэний материалыг 2018 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 17:00 цаг хүртэл хүлээн авна. Материалыг битүүмжлэн ирүүлэх шаардлагатай.

АНХААРАХ ЗҮЙЛС:

1. Материалыг битүүмжлэн байх ба дугтуйн гадна талд сонгон шалгаруулалтад оролцогч иргэний нэр, оршин суух хаяг, холбоо барих утасны дугаарыг гаргацтай бичнэ.
2. Материалыг сонгон шалгаруулалтын дараа буцаан олгохгүй.
3. Хугацаа хоцорсон материалыг хүлээн авахаас татгалзана.
4. Материалын бүрдэл дутуу тохиолдолд сонгон шалгаруулалтаас хасна.
5. Ирүүлсэн материал нь сонгон шалгаруулалтын шаардлага хангасан иргэнтэй нэр дэвшүүлэх хорооноос холбоо барина.

ZGM DAILY

OZD Capital PTE Ltd. enters Mongolian mining sector

Centerra Gold sells their assets in Mongolia at USD 35 million.

PM Khurelsukh Ukhnaa visits Altanshree oil refinery

Construction of the refinery, which began in June 2018, is 40 percent complete.

BoM launches Digital Era-Digital Payment two-month campaign

2 companies have requested rights for digital currency.

Top 20 Index remains stable at 20,463.69 points

Market cap stands at MNT 2.4 trillion.

ZGM: HIGHLIGHTS

POLITICS

Parliament to discuss bill on amending Law on Currency Regulation this week. Approval of the bill will potentially allow the Bank of Mongolia (BoM) to restrict foreign exchange withdrawal and transaction.

Defense Minister of the Russian Federation, Army General Sergey Shoigu to pay an official visit to Mongolia on October 18 at the invitation of his Mongolian counterpart Enkhbold Nyamaa.

ECONOMY

Number of internet users grew 22.5 percent, to 2.6 million in Mongolia in the first half of this year.

Gold testing laboratory commissions in Darikhan-Uul aimag. Swiss Agency for Development and Cooperation highlights the lab will help reduce the unofficial gold delivery processes and increase the gold purchase of the BoM.

Top 20 Index remains stable at 20,463.69 points. MSE A Index decreases 0.03 percent, to 9,789.25 points. MSE B Index grows 0.66 percent, to 8,973.3 points. Market cap stands at MNT 2.4 trillion.

SOCIETY

Mongolian Women's Federation elects Oyungerel Batnasan, Director General at ISO Mongolia LLC as the President of the federation.



Australian firm acquires Centerra Gold assets in Mongolia

OZD Capital invests in Mongolia through its subsidiary OZD Asia

Tugsbilig.B
@tugsbiligZGM

Brisbane-based Australian firm OZD Capital has announced that the company is investing in Mongolia through its subsidiary OZD Asia PTE Ltd. In other words, the company is investing in Mongolia's mining projects by acquiring Centerra Netherlands and Centerra Gold Mongolia LLC, which is the 100 percent direct shareholder of Boroo Gold LLC. OZD Capital is the parent

Centerra Gold assets in Mongolia valued at USD 35 million

company of OZD Asia PTE and focuses on emerging markets, specifically in mining and metal

assets by financing and operating them. The company is largely owned by Australian, Singaporean and Mongolian stakeholders.

A board member of OZD Capital highlighted, "The deal aligns with the company's core strategy to invest and operate mining and metal assets of emerging markets." OZD Capital also informed that they have precious metal assets in Asia, South America and West

Africa.

The company is headquartered in Brisbane, Australia and has branch offices in Singapore and Mongolia. As for OZD Asia, which signed the deal, is registered in Singapore.

While Mongolian projects were valued at USD 35 million, the total amount of the agreement totalled USD 90 million according to OZD Capital. [ZGM]

INDUSTRY

Construction of national oil refinery 40 percent complete



Tugs.B
ZGM

Prime Minister Khurelsukh Ukhnaa had a field trip to Altanshree soum of Dornogobi aimag to get an au fait with the construction of an oil refinery yesterday. Officials disclosed that the construction is currently 40 percent complete.

With an aim to fulfill their promise to move the mega projects, the Government commenced the construction of the oil refinery

and its infrastructure on June 22, 2018 under USD 1 billion soft loan from the Republic of India. The factory is expected to have a capacity of processing 1.5 million tons of oil and be commissioned by 2022.

The PM also visited MAK LLC's Euro Block factory in Sergelen soum, Tuv aimag. Engineers of the factory highlighted that the Euro Block insulation is 40 cm in width, which can provide enough heat retention without the use of additional thermal insulations. Since its establishment in

2015, the factory manufactured around 310,000 square meters of insulation and has a capacity to produce 270,000 square meters of block insulations.

The PM Khurelsukh also visited MAK Euro Cement plant, which was based on Khukh Tsav cement and lime deposit. According to the company, the plant is capable of producing 1 million tons of cement and 100,000 tons of lime. MAK Euro Cement makes up over 40 percent of domestic demand, while Euro Block accounts for 60 percent. [ZGM]

MONETARY POLICY

BoM launches Digital Era-Digital Payment campaign

Within the frames of reforming the payment system in Mongolia, the Bank of Mongolia (BoM) discloses plans on transforming "T" card into EMV/NFC chip technology, introducing automated clearing system and digital signature system in financial institutions.

Accordingly, the BoM decided to launch a two-month campaign themed Digital Era-Digital

Payment.

The draft of 2019 Monetary Policy Guidelines includes supportive measures on fintech development. For instance, the draft allows diversification of fintech products and services range. The bank also signified the importance of involving non-banking financial institutions and tech companies in the payment system.

Additionally, tech companies are

actively engaging in Mongolia's national payment system. For example, MobiFinance NBF received their permission to launch the first digital currency from the BoM. This became a benchmark for digital currencies as entities can now request special rights for digital currencies from the BoM. The bank has informed that 2 companies have already requested for digital currency rights. [ZGM]



МОНГОЛЫН ИПОТЕКИЙН КОРПОРАЦИ
MONGOLIAN MORTGAGE CORPORATION

САНХҮҮГИЙН ХӨНДЛӨНГИЙН ШИНЖЭЭЧЭЭР АЖИЛЛАХ КОМПАНИЙН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАР

Монголын Ипотекийн Корпораци нь "МИК Актив Арван Ес" ХХК-иар дамжуулан ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргахтай холбогдуулан санхүүгийн хөндлөнгийн шинжээчээр хамтран ажиллах компанийн сонгон шалгаруулалтанд оролцохыг урьж байна.

Хөндлөнгийн шинжээч нь ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргах хэлцлийн хүрээнд хийж гүйцэтгэсэн шинжилгээнд дүгнэлт гаргах болон гүйцэтгэсэн шинжилгээний талаар тайлан бэлтгэж "МИК Актив Арван Ес" ХХК болон түүний үүсгэн байгуулагч "МИК ОССК" ХХК нарт танилцуулах, тайлбар хүргүүлэх ажилбаруудыг гүйцэтгэнэ.

Санхүүгийн хөндлөнгийн шинжээчид тавигдах шаардлага

Ипотекийн зээлээр баталгаажсан бондын хэлцлийн хүрээнд хөндлөнгийн шинжилгээ гүйцэтгэх этгээд нь дараах үндсэн шаардлагуудыг хангасан байх бөгөөд зөвхөн доорхоор хязгаарлагдахгүй.

- Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 33.2-т заасан санхүү, аудитын зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй хуулийн этгээд байх;
- Санхүүгийн хөндлөнгийн шинжээчийн дүгнэлт үйлчилгээний хүрээнд хийгдэх зөвлөх болон дүгнэлт гаргах сонирхлын зөрчилгүй, гүйцэтгэсэн ажилд баталгаа гаргах чадвартай байх;
- Зээлийн хөрөнгө, зээлийн материал болон бондод, санхүү, бүртгэлийн үйлчилгээ үзүүлж байсан туршлагатай, Монгол Улсын холбогдох хууль, тогтоомж, журмын талаар өргөн мэдлэг, туршлагатай байх;
- Санхүүгийн шалгуур хангасан эсэхэд хөндлөнгийн шинжилгээг гэрээгээр тохирсон хугацаанд чанартай гүйцэтгэх мэдлэг чадвар, хүсэл эрмэлзэл, хүний нөөц болон цаг хугацааны нөөц бололцоотой байх.

Сонгон шалгаруулалтанд бүрдүүлэх материал

- Хамтран ажиллах санал
- Үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хуулбар
- Хөндлөнгийн шинжээчид тавигдах шалгуурыг хангасан талаар бичгээр баталгаажуулсан баримт. Үүнд:
 - СЗХ-ны бүртгэгдсэн эсэхийг нотлох баримтын хуулбар
 - Үнэт цаасны зах зээлийн эрх зүйн талаар сургалтад хамрагдсан эсэхийг нотлох баримтын хуулбар
 - Хөндлөнгийн шинжилгээ хийх үйлчилгээ, тайлан дүгнэлтийг ашиг сонирхлын зөрчилгүй, зохих журмын дагуу гүйцэтгэх талаарх баталгааг албан тоотгоор ирүүлэх

Материал ирүүлэх хугацаа, хаяг

Сонгон шалгаруулалтанд оролцохыг хүссэн албан байгууллага дээрх материалыг бэлтгэж, битүүмжлэн 2018 оны 10 дугаар сарын 17-ны өдрийн 17:00 цагаас өмнө "Монголын ипотекийн корпораци ОССК" ХХК-ийн Эрсдэлийн удирдлагын газарт хаяглан ирүүлнэ үү.

Заасан хугацаанаас хоцорсон тохиолдолд санал ирүүлээгүйд тооцно.

Жич: "МИК ОССК" ХХК-иас зөвхөн сонгон шалгаруулалтын шаардлага хангасан байгууллагад хариу мэдэгдэж хийж гүйцэтгэх ажлын даалгаврыг хүргүүлнэ.

Нэмэлт тодруулга авах шаардлагатай бол тус компанийн Эрсдэлийн мэргэжилтэн Ө.Наранчимэг (цахим хаяг: naranchimeg.u@mik.mn; Утас: 328267 (839)-тай холбогдоно уу.

Өдрийн хэмнэл

ТВ ХӨТӨЛБӨР



- 09.55** Эрхзүйн хөтөч
- 15.15** Хөгжлийн замаар: Зочид буудал
- 16.45** Ярилцлага: Монгол Улсын Ерөнхийлөгч Халтмаагийн Баттулга оролцоно.
- 19.00** "Ази дахь зөвлөлдөх ардчиллын туршлага" ОУ-ын эрдэм шинжилгээний бага хурлаас
- 21.10** Дэлхийн түүхүүд: "Детройт хотын сүйрэл" баримтат кино
- 23.30** "Гэрэлтэй цонх" үдшийн хөтөлбөр

Bloomberg TV Mongolia

- 06.00** Мөнгөний урсгал Мэдээний хөтөлбөр давталт
- 11.00** Сая долларын суутан Нэвтрүүлэг
- 15.00** Бизнесийн төв цэг Мэдээний хөтөлбөр
- 20.00** #Made in Mongolia Баримтат цуврал нэвтрүүлэг
- 22.00** Удирдагчид Лакуатай хамт Нэвтрүүлэг
- 22.30** Хариуцлага ба үнэ цэнэ Нэвтрүүлэг

БОЛОВСРОЛ HD

- 08.00** "4 өнгө" цаг агаарын хөтөлбөр
- 09.00** "Монголчууд ХХ зууны эхэнд" нэвтрүүлэг
- 11.20** Үүнийг хэрхэн хийдэг вэ?
- 14.05** "Та 5 дугаар ангийн хүүхдээс ухаантай юу?" шоу нэвтрүүлэг
- 20.25** "Export" нэвтрүүлэг
- 21.40** "Монголчууд ХХ зууны эхэнд" нэвтрүүлэг



- 12.00** Хөтөч мэдээллийн хөтөлбөр
- 14.30** "Заншлын хэлхээ-Дээд Монголчууд" 2-р хэсэг
- 17.30** "Мөрдөгч хүүхдүүд" ОАК /season-1/ 43, 44-р хэсэг
- 19.00** Оргил цаг мэдээллийн хөтөлбөр
- 21.00** "Ороод гараач" /season-2/ 17-р анги
- 00.30** "Өмнө зүгийн хатан хаан" /season-1/ 8-р анги

ЗУРХАЙ



Билгийн тооллын 7
Намрын адаг хар нохой сарын таван шар мэнгэтэй, цагагчин могой өдөр
Үс засуулбал: Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ
Наран ургах, шингэх: 07.13-18.03
Барилдлага: Үхэх
Шүтэн барилдлага: Нэр өнгө
Суудал:Шороо

Аргын тооллын аравдугаар сарын 16, Анграг гараг. Билгийн тооллын 7, Суулга одтой, цагагчин могой өдөр.
Өдрийн наран 07.13 цагт мандан, 18.03 цагт жаргана. Тухайн өдөр үхэр жилтнээ аливаа үйл хийхэд эерэг сайн ба бич, тахиа жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамаг хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах, хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сүм дугана сэргээх, газар лусын зан үйл хийх, өр барагдуулах, буг дарах, газрын ам бооход сайн. Ургаа мод таслах, газрын ам нээх, гөлөг тэжээх, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу. Өдрийн сайн цаг нь үхэр, луу, морь, хонь, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

ОНЦЛОХ ҮЗВЭР

Орчин үед амилсан "Севилийн үсчин"



"Люмино"-гийн 20 жилийн ойн тоглолт
Хаана: Crocus Event Hall
Хэзээ: 2018.10.19, 20-нд 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 40 мянга



Монгол цирк
Хаана: Монголын үндэсний Аса цирк
Хэзээ: 2018.10.26-ны 17.00, 10.27-ны 13.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 15 мянга



Б.Шаравын "Чингис хаан" дуурь
Хаана: УДБЭТ
Хэзээ: 2018.10.26-27-нд 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 10-20 мянга



УДБЭТ-ын шинэ улирлын нээлтийн тоглолтод дэлхийн хамгийн алдартай хошин дууриудын нэг Ж.Россиний "Севилийн үсчин" бүтээл багтжээ. Уг дуурийг Италийн нэрт найруулагч Стефано Монтигийн цоо шинэ тавилтаар үзэгчдэд хүргэх юм. Энэ алдарт бүтээл 200 орчим жилийн өмнө зохиогдсон. Харин энэ удаа дуурийн үйл явдлыг бүтэн

зуунаар наашлуулан, дэлхийн эдийн засаг, соёлын үсрэнгүй хөгжлийн зуун болох XIX зуунд болгон хөрвүүлэн тавьж буйгаараа онцлог. УДБЭТ-ын уг шинэ бүтээлд уран сайхны удирдагч А.Дашпэлжээ, найруулагч С.Монти, удирдаач Ц.Гансүх, ерөнхий зураач Г.Ганбаатар нар ажиллаж байна. "Севилийн үсчин" дуурийг анх 1816 онд Италийн

"Аргентина" театрт тогложээ. 200 гаруй жил тайзнаа амьдарсан уг дуурь дэлхийн олон театрт өөр өөр найруулга, өнгө төрхтэйгээр үзэгч олонд хүрч, тайзнаа хамгийн олон удаа тоглогддог дуурийн жагсаалтын тэргүүнд бичигдсээр байна. Энэ сарын 20-нд 17.00 цагт тоглогдох уг дуурийн тасалбар 10-20 мянган төгрөгийн үнэтэй. [ЗГМ]



"Шопен ба Шарав" төгөлдөр хуурын сонгодог
Хаана: Чингис хаан зочид буудал
Хэзээ: 2018.11.03-нд 17.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 50-60 мянга




"Гамлет" монодрам
Хаана: Corporate Convention Centre
Хэзээ: 2018.11.02-нд 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 80-100 мянга



"Дөмөн Хонгор аялгуу" тоглолт
Хаана: Corporate Convention Centre
Хэзээ: 2018.11.02-нд 19.00 цагт
Тасалбарын үнэ: ₮ 40-60 мянга

ЗГМ: ҮГИЙН СҮЛЖЭЭ



- 15. Дэмжлэг тус
- 16. Эрх баригч нам
- 17. Ганц бие

- гайхамшгийг үзүүлсэн кино
- 18. Оросын пролетарийн хувьсгалын

- удирдагч
- 19. Дорнод Монголын уудам тал

хөндлөнгөөр:

- 1. ... барьц
- 5. Хавтгай таваг
- 6. Ургамлаас гаргаж авдаг уяа оосор
- 9. Чехийн зохион бүтээгч Рубикийн зохион бүтээсэн тоглоом
- 10. Гол усаар гатлан гарах гарц
- 11. Монгол орны хамгийн том нуур
- 12. Морин хуурын

Өмнөх дугаарын хариу / 10.15



ЦАГ АГААР

УЛААНБААТАР




ФОТО АГШИН



Билиг танхай монгол ухаан.

Б.Хасуй / ЗГМ

ЗГМ: СҮДОКУ

				2	4			
	5	1						
			5	3				1
		8				1	4	
2		3	9					
6								
3	6	4						
			8			7		
	2	7	5					

5	1	2	7	6	3	9	8	4
8	6	3	9	2	4	5	7	1
7	4	9	5	1	8	2	6	3
9	5	8	4	3	6	1	2	7
6	2	7	1	8	5	3	4	9
1	3	4	2	9	7	6	5	8
2	8	1	6	4	9	7	3	5
4	9	5	3	7	2	8	1	6
3	7	6	8	5	1	4	9	2

(Анхны нөхцөл хөнгө)



ГАЛТ ТЭРЭГНИЙ ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-МОСКВА	13.50	14.28
МОСКВА-УБ	21.35	07.30
УБ-ЭРХҮҮ	21.10	02.40
ЭРХҮҮ-УБ	15.35	06.20
УБ-СУХБААТАР	21.15	05.12
СУХБААТАР-УБ	20.55	05.03
УБ-ЭРДЭНЭТ	20.30	07.45
ЭРДЭНЭТ-УБ	19.10	05.48
ЗАМЫН-ҮҮД-УБ	17.35	08.55
УБ-ЗАМЫН-ҮҮД	17.20	07.05



НИСЛЭГИЙН ЦАГИЙН ХУВААРЬ

УБ-БЭЭЖИН	06.10	08.25
БЭЭЖИН-УБ	09.30	12.00
УБ-СӨҮЛ	08.40	12.50
СӨҮЛ-УБ	14.20	17.00
УБ-ТОКИО	07.45	13.40
ТОКИО-УБ	14.40	19.15
УБ-ЭРХҮҮ	07.50	09.15
ЭРХҮҮ-УБ	10.15	11.45
УБ-МАНЖУУР	15.10	17.30
МАНЖУУР-УБ	18.20	20.50
УБ-МОСКВА	09.15	10.55
МОСКВА-УБ	00.00	06.00

© The Financial Times Limited (2015). All Rights Reserved. Not to be redistributed, copied or modified in anyway. ZGM is solely responsible for providing these translated articles and the Financial Times Limited does not accept any liability for the accuracy or quality of the translation.

Геополитикийн зөрчил ОУВС-гийн уулзалтыг сүүдэрлэв

ОУВС-гийн уулзалтад оролцогчид ирээдүйн төлөвт итгэл дундуур буйгаа илэрхийлжээ. > 10

L3 ба Harris цэргийн салбарт хүчээ нэгтгэв

Хоёр компани цэргийн салбарт дэлхийд дээгүүр бичигдэх 33.5 тэрбум ам.долларын үнэлгээтэй групп боллоо. >10

Английн банк уур амьсгалын өөрчлөлтөд бэлтгэхийг уриаллаа

Урт хугацааны эрсдэлийг бууруулахын тулд ойрын алхам хийх ёстойг төв банкууд уриалжээ. >10



Боб Принс: “Эдийн засаг чанга тогтвортой байдлаас сул нөхцөл рүү шилжиж болзошгүй эргэлтийн цэг дээр ирээд байна”.

дахих аюултайг ноён Принс анхааруулав.

Тэрбээр “Түүхнээ замхран одох энэ долоо хоногийг бид мартацгааж ч магад. Гэхдээ л мөнгөний зөөлөн бодлого хатуу руугаа шилжиж байгаа нь илт байна. Хэрвээ энэ доржилт нь өсөлт эхэлж буй цэг мөн байвал ганц долоо хоног үргэлжлээд зогсохгүй” гэв.

Татвар хөнгөлсөн нь АНУ-ын эдийн засгийг амь оруулж, ажилгүйдэл 1969 оноос хойш тохиолдоогүй бага хувьтай боллоо. Хэрэглэгчийн итгэл 2000 оноос хойш тохиолдож байгаагүйгээр сайжирч, үйлчилгээний салбарын идэвх 1997 оноос хойших үнэмлэхүй түвшинд

► Альтернатив намд санал өгөгчид олширчээ

Кги Шазан
ХБНГУ-ын өмнөдийн муж улсад ням гарагт гарсан сонгуулийн дүн Баварийн эрх баригч Христийн Социал Холбоо намд төдийгүй Берлин дахь Ангела Меркелийн их эвсэлд оролцогч бүх намд цохилт боллоо. Баварийг 1957 оноос хойш удирдаж буй Христийн Социал Холбоог дэмжигч нар таван жилийн өмнөх сонгуулиар 47.7 хувьтай байсан бол энэ удаа 36.2 хувь боллоо цөөрснийг ZDF телевиз мэдээлэв. Ногоон нам, хэт барууны Германы Альтернатив намд санал өгөгчдийн тоо энэ удаа өссөн байна.



► Саудын Араб АНУ-ын анхааруулгад хариу өглөө

Дэвид Шеппард
Сураггүй болсон сэтгүүлч Жамал Хашоггийн төлөө АНУ хориг тавьбал эдийн засгийн хүчин чадлаа зэвсэг болгон ашиглана хэмээн Саудын Араб сүрдүүлсэн. Үүний дараа ням гарагт Brent газрын тосны фьючерсын үнэ бараг хоёр хувь өсөж, баррель нь 82 ам.долларт дөхлөө. Дэлхийн газрын тосны тэргүүлэх олборлогч, АНУ-ын гол холбоотны нэг Саудын Арабыг нэртэй сэтгүүлчээ хөнөөсөн байж болзошгүй хэмээн сэжиглэж байгаа нь тус улсад бэрхшээл учруулаад байна. Саудын эрх баригчид ноён Хашоггиг хөнөөсөн нь батлагдвал “ноцтой цээрлэл үзүүлнэ” хэмээн АНУ-ын Ерөнхийлөгч Дональд Трамп сүрдүүлсэн юм.

Эдийн засаг сулрах аюултай

Робин Уиглсворт

Мөнгөний хатуу чанд бодлого хүнд ачаа болж, санхүүгийн зах зээлд дарамт учруулах хэрээр АНУ-ын эдийн засгийн өсөлтийн эрч саарах аюултайг дэлхийд тэргүүлэгч хедж сан анхаарууллаа.

Бодлогын хүүг өсгөж, татвар хөнгөлсний үрээр энэ онд эрчимтэй сайжирсан эдийн засаг болон компаниудын ашиг орлого бараг оргилдоо тулсан хэмээн Bridgewater-ын хөрөнгө оруулалт хариуцсан орлогч захирал Боб Принс үзэж байна.

“Ирээдүйн ашиг орлоготой холбоотой энэ бүх өөдрөг бодол үнэт цаасны үнийг өсгөхөчлөө. Гэтэл эдийн засаг чанга тогтвортой байдлаасаа сул нөхцөл рүү шилжиж болзошгүй эргэлтийн цэг дээр ирчихээд байна” хэмээн ноён Принс өгүүлсэн юм. “Мөнгөний хатуу чанга бодлого эрс уналт

үүсгэхгүй ч дарамт болох шаг ойртож байна” хэмээн Bridgewater-ын 160 тэрбум ам.долларын хөрөнгөтэй тус санг үндэслэгч Рэй Далио, хөрөнгө оруулалт хариуцсан захирал Грег Йенсен нар анхааруулав.

АНУ-ын эдийн засгийн сайн үзүүлэлттэй статистик, Холбооны Нөөцийн Системийн удирдлагын дайчин тайлбар ирээдүйг тооцоолох хөрөнгө оруулагчдын байр суурийг өөдрөг болгов. Чухам уг нөхцөлөөс шалтгаалан АНУ-ын Сангийн яамны үнэт цаасны өгөөж энэ сарын эхээр огцом өссөн юм.

Эдийн засгийн таатай олон мэдээ бондын зах зээлд ч нөлөөлж, АНУ-ын Сангийн яамны үнэт цаасны өгөөжийг огцом өсгөж орхив. Өнгөрсөн долоо хоногт АНУ-ын хөрөнгийн зах зээлийг донсолгосон уг огцом өсөлт S&P

Дэлхийн үнэт цаасны үнийн өсөлт (MSCI All Country World Index)



500 индексийг сүүлийн хагас жилд тохиолдоогүй унагаж, улмаар дэлхийн зах зээлийг нийтэд нь доргиолоо. Баасан гарагт ихэнх бирж хэвийн нөхцөлдөө эргэн орж, АНУ-ын Сангийн яамны үнэт цаасны өгөөж долоон жилийн үнэмлэхүй өсөлтөөсөө буцаж буусан юм. Гэхдээ АНУ-ын Холбооны Нөөцийн Систем тэргүүтэй голлох төв банкууд мөнгөний бодлогоо чангатгаж буйтай уялдан цаашид донсолгоо

сэргэв. Холбооны Нөөцийн Систем эдийн засгийн өсөлтийг 2018 онд гурваас дээш хувьтай болно хэмээн тооцоолж байна.

Гэхдээ АНУ-ын төв банк бодлогын хүүгээ арванхоёрдугаар сард дөрөв дэх удаагаа, ирэх 2019 онд дахиад гурван удаа өсгөх гэж байгаа нь эдийн засгийн өсөлтийг сааруулж таарна. Холбооны Нөөцийн Систем хямралын үеэр ихээр ихэсгэсэн бондын тайлан тэнцлээ ч зэрэг бууруулаа.



Борлуулалтаараа манлайлж буй эмийг хүлээх нь

AbbVie-гийн үе мөчний үрвэсэл эмчлэх Humira эмийн борлуулалт 2017 онд 18 тэрбум ам.доллар болжээ.



Сара Невилл

Био эмийн ертөнцөд боломж хязгаартай. Дэлхийд борлуулалтаараа тэргүүлдэг Humira эмийг жоргүй олгодог ердийн эмийн өрсөлдөөнөөс 15 жил хамгаалсан патентын хугацаа Европт тивд дууслаа. Ийн патентын хугацаа дуусаж байгаа нь эм үйлдвэрлэгч компаниуд 20 тэрбум ам.долларын зах зээлд өрсөлдөх шинэ өрсөлдөөн үүсгэв.

АНУ-ын AbbVie группийн бүтээгдэхүүн-Humira эмийн дэлхий даяарх борлуулалт 2017 онд 18.43 тэрбум ам.долларт хүрснийг өгөгдлийн Evaluate-Pharma компани тооцоолжээ. Уг тооцоогоор борлуулалт 2024 он гэхэд 14.19 тэрбум болж буурахаар байгаа юм.

Зах зээлд Humira эмийн биосимиляр буюу ижил хувилбарыг нь борлуулахаар Amgen, Sandoz, Biogen, Samsung Bioepis зэрэг олон том компани өрсөлдөж байна. Японы Fujifilm Kyowa Kirin Biologics компани Humira-гийн аналог болох Hulio эмийг АНУ-ын Mylan компанитай хамтран Европт борлуулах онцгой эрх хэдийн эзэмшжээ. Харин ижил эмийг Европын Холбоонд борлуулах зөвшөөрөл авсан ХБНГУ-ын Boehringer Ingelheim компани AbbVie-тэй хийж буй патентын заргын улмаас

бүтээгдэхүүнээ тус тивд зарах аргагүй боллоо.

Европ нь Humira эмийн дөрвөн тэрбум ам.долларын зах зээл болж өгдөг. Зөвхөн Их Британид жилдээ уг эмийг авахад 635 сая ам.доллар зарцуулж байгааг Mylan-ы худалдаа эрхэлсэн захирал Тони Мауро тайлбарлав. Энэхүү эмийг хэрэх өвчин, үе мөчний үрвэсэл, хайрст үлд, Кроны өвчин буюу гэдэсний шархлаат үрэвсэл зэрэг олон өвчинд хэрэглэдэг.

Хамгийн их хэрэглээтэй ганц эм гэдэгтэй юм гэхэд борлуулалт сайтай гол эмийн нэг учир улс орны засгийн газар, эрүүлийг хамгаалах байгууллага бүгд сонирхож байгааг тэрбээр дурдлаа.

Харин AbbVie компанийн хувьд эмийнх нь патентын хугацаа дуусаж байгаа нь ноцтой аюул болно. Ердөө 2017 онд тус компани Humira-гаас нийт орлогынхоо 66.4 хувийг олжээ. Evaluate-ын тооцоогоор, зургаан жилийн дараа буюу 2024 онд уг хувь 39.2 хүрч буурна. AbbVie компани өөрийнх нь гол зах зээл болох АНУ-д патентаа ядаж 2023 он хүртэл хадгалж үлдэхээр шүүхэд зарга мэдүүлээд буй.

Ярилцлага өгөхөөс татгалзсан AbbVie компани тус эмийн оронд хэрэглэх аюулгүй, үр дүнтэй биосимиляр хэрэглээнд шинээр

нэвтрүүлэхийг дэмжихээ илэрхийлжээ. Гэхдээ “одоогийн эмчилгээнд хамрагдаж буй өвчтнүүд эмнэл зүйн бус шалтгаанаар өөр бүтээгдэхүүнд шилжих ёсгүй” хэмээн нэмж тайлбарласан юм.

Молекулын цогц нарийн бүтэц бүхий, биотехнологийн эмийн ижил хувилбар буюу биосимиляр нь “брэнд эмийн компаниудад шинэ аюул занал учруулж байгаа”-г зээлжих зэрэглэлийн Moody’s агентлаг энэ сард нийтэлсэн тайландаа анхаарууллаа. Өсөн торниж буй шинэ үеийнхэн, өтөлж буй настай иргэдийн эрүүл мэндийг хамгаалах зардалаа багасгахаар чармайж буй улс орнуудын эрүүлийг хамгаалах байгууллагууд ч биосимилярт шилжихийг дэмждэг. Биосимилярыг хэрэглээнд нэвтрүүлэх дэлхий нийтийн үйлсийг Европ тив хошуучилж явна. Их Британийн татвар төлөгчдийн мөнгөөр санхүүждэг Үндэсний Эрүүлийг Хамгаалах Үйлчилгээнд (National Health Service) хамрагдаж өвчтнүүдийн 80 хувь нь Швейцарын Roche компанийн бүтээгдэхүүн буюу цусны хавдар эмчиддэг Rituximab эмийн биосимиляр ашиглаж байна.





ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНКНЫ РИВЕР ГАРДЕН САЛБАР НЭЭЛТЭЭ ХИЙЛЭЭ



Худалдаа, хөгжлийн банк нь харилцагчид хүндэтгэн шинэлэг, тав тухтай орчинд үйлчлүүлэх боломжийг байнга эрэлхийлж ажилладаг билээ. Энэ ч үүднээс 2018 онд олон улсын стандарт бүхий тохижилттой 5 шинэ салбараар үйл ажиллагаагаа өргөжүүлсэн ба 10-р сарын 12-ны өдрийн билэгт сайн өдөр хамгийн отгон Ривер Гарден салбарынхаа нээлтийн арга хэмжээг харилцагчдынхаа халуун алга ташилтан дунд ёслол төгөлдөр хийлээ.

Худалдаа, хөгжлийн банк 28 жилийн турш иргэд, бизнес эрхлэгчдийн санхүүгийн найдвартай түнш, тогтвортой, итгэлтэй хамтрагч нь байсаар ирсэн. Мөн салбаруудын тохижилт, харилцагчийн үйлчилгээний стандартаараа арилжааы банкны жишгийг шинэчлэн тогтоосоор ирсэн. Энэ ч үүднээс Их Британийн “Allen international consulting group” компанитай хамтран ажиллаж, салбарууддаа олон улсын стандартын дагуу шинэ өнгө төрх оруулж, харилцагчдаа илүү тав тухтай орчинд үйлчилгээгээ авах эхлэлийг тавьж байсан. Энэ ондоо шинэ салбарууд нээхээс гадна үйл ажиллагаа явуулж байсан салбаруудынхаа тохижилтыг ч шинэчиллээ.

Та бүхэн Ривер Гарден салбараар тав тухтай орчинд үйлчлүүлэн нээлтийн урамшуулалд хамрагдаарай.

ХӨГЖИЛ ДЭВШИЛД ХАМТДАА

Крис Жайлз

Индонезийн Бали аралд болсон ОУВС-гийн уулзалтад оролцогч Сангийн сайд нар болон Төв банкуудын захирагч нар өнгөрсөн долоо хоногт дэлхийн зах зээл уруудсаныг хэлэлцсэнгүй. Тэд геополитикийн хурцадмал байдалд анхаарч, ирээдүйн төлөвт итгэл дундуур буйгаа илэрхийлсэн. Дэлхийн эдийн засаг сайн байгаа хэдий ч зарим шинэ зах зээл дэх санхүүгийн асуудал халдварлаж, дэлхийн байгууллагууд түүнийг шийдэх уялдаа муу байгааг тэмдэглэв. ОУВС-гийн захирал Кристин Лагард улс орнуудад хандаж, дэлхийн эдийн засгийн өсөлтийг хадгалахын тулд “хамтдаа хөвөхийг” чухалчлан уриалсан боловч хамтын алхам хийхэд улам хүндрэлтэй болж байна.

Индонезийн Ерөнхийлөгч Жоко Видодо “Гол эдийн засгуудын харилцаа хаадын тоглоомтой улам адилхан болж байгаа тул эмгэнэлт төлөөсийг бүгд хуваалцана” хэмээн анхаарууллаа. АНУ-ын Ерөнхийлөгч саяхан холбооны нөөц хяналтаас гарч, хувьцааны үнэ унаж буйг шүүмжилсэн нь олон нийтийг цочроов. Гэвч өөр олон асуудал байгааг Европын Төв банкны Ерөнхийлөгч Марио Драги онцолжээ. Тухайлбал, хөрөнгийн үнэ болон бодлогын хүү огцом дээшилж магадгүй гэжээ. Дэлхийн тэргүүлэгч хоёр эдийн засаг энэ онд 360 тэрбум ам.долларын өртөгтэй бараанд тариф тогтоосон бөгөөд ойрын сард дахин нэмэгдэх төлөвтэй байгаа тул ОУВС, Дэлхийн банк болон бусад улсуудын албаныхан Вашингтон, Бээжинд хандан байдлыг намжааж, эвлэрэлд хүрэхийг хичээнгүйлэн хүссэн байна.

Гарсан бодит үр дүн бага боловч хоёр талын үг яриа арай зөөлрөөд буй. АНУ-ын Сангийн сайд Стивен Мнучин бямба гарагт сэтгүүлчдэд ярихдаа худалдааны зөрчлөө арилгахыг эрмэлзэж байна гэсэн. Тэрбээр Хятадын Төв банкны захирал И Ганаас юанийн ханшийг



BBM©

ОУВС, Дэлхийн банк болон улсуудын албаныхан Вашингтон, Бээжинд хандан байдлыг намжааж, эвлэрэлд хүрэхийг хичээнгүйлэн хүссэн байна.

Геополитикийн зөрчил ОУВС-гийн уулзалтыг сүүдэрлэв

бодлогоор унагаж, өрсөлдөх чадвараа дээшлүүлэхгүй гэсэн амлалт авснаа мэдээлэв. Ноён И Ган ОУВС-д ирүүлсэн захидалдаа мөн уг амлалтаа нотолжээ. Ноён Мнучин түүнчлэн Хятадын талд хариу арга хэмжээ болгож, АНУ-ын үнэт цаасыг бөөнөөр худалдах таамгийг няцаав.

Тэрбээр “АНУ-ын өрийг худалдан авагч олон байгаа тул энэ асуудлаар ноёр алдах зүйл алга” хэмээн ярьжээ. Ийн түүний хэлснээс ойрын үед тохиролцоонд

хүрэх дохио ажиглагдсангүй. Хэлэлцээ үргэлжилсээр буй боловч ирэх сард Аргентинд болох Их 20-ийн уулзалтаар ноён Трамп Хятадын Төрийн тэргүүн Ши Жиньпинтэй уулзахаас өмнө шийдэлд хүрэхгүй бололтой. Мнучин хэлэхдээ “Хятадын талаар манай зорилго тодорхой. Энэ бол илүү тэнцвэртэй худалдааны харилцаа” хэмээв.

Үүний зэрэгцээ Итали болон ЕХ-ны хоорондын зөрчил илэрхий болсон авч талууд тайван

байхыг уриалаад буй. Италийн иргэн ноён Драги “Өр ихтэй улсад төсвийн тэлэлт яригдаж байгаа учир маргаан гарах нь зайлшгүй. Гэхдээ манай улсын иргэд еврод эргэлзэж эхэлбэл асуудал бүр хүндэрнэ. Миний бодлоор хоёр талын мэдэгдэл бодит хохирол учруулсан. Түүнчлэн үүнээс үүдсэн хохирол тархсан шинж ажиглагдаж байна” хэмээн тайлбарлав. ОУВС-гийн Европыг хариуцсан ажилтан Поул Томсен “Татварын бодлогыг зөөлөх цаг

үе биш” хэмээсэн нь Италийг зэмлэсэн хэрэг юм.

Азийн хувьд Хятадын “Бүс ба зам” төсөлтэй холбоотой төсвийн ил тод байдлын асуудал байгааг Дэлхийн банкны ажилтан Каролин Фрейнд анхаарууллаа. Брукинсийн хүрээлэнгийн зөвлөлийн гишүүн Дэвид Доллар “Бага орлоготой зарим улс ийм зээлийг төлөх чадваргүй. Иймээс Хятадын тал тухайн улсын татварын тогтвортой байдлыг сайн харж, арилжааны

зээл авч чадахааргүй орнуудад илүү хөнгөлөлттэй зээл олгох нь зүйтэй” гэжээ. Харин Хятадын Сангийн дэд сайд Зоу Жийай “Бээжин төсөлд хамрагдсан орнуудын төлбөр болон оролцогчийн чадамжид их анхаардаг. Энэ бол манай мөнгө. Хятадын Засгийн газар тэдгээр зээлдэгчдийн өрийн тогтвортой байдлыг нягтлах судалгааны чадамжаа дээшлүүлэхийг дэмждэг” хэмээн хариу мэдэгджээ.



Дэлхийн томоохон 18 төв банкны удирдлага уулзаж, уг эрсдэлд хариу арга хэмжээ авахгүй бол бүх салбарыг хамарч, нөхөгдөшгүй хохиролд орж болзошгүйг анхааруулав.

BBM©

Английн банк уур амьсгалын өөрчлөлтөд бэлтгэхийг уриаллаа

Лесли Хук

Английн банк мэдэгдэл боловсруулж байна. Уг мэдэгдэлд банкууд болон даатгагчдад хандан урт хугацааны төлөвлөлтөдөө уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг тусгаж, хангалттай арга хэмжээ аваагүй байгууллагын удирдагчдад хариуцлага хүлээлгэхийг шаардахаар тусгажээ. Дэлхийн санхүүгийн төвийн гол зохицуулагч даваа гарагт уг мэдэгдлээ банк болон даатгагчдын захирлуудын зөвлөлд гардуулахаар бэлтгэв. Мөн захирлууд уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг хариуцан зөвлөлдөө тайлан бэлтгэж өгөх, эс бол хариуцлага хүлээх тухай дурджээ.

Дэлхий даяар санхүүгийн зохицуулагчид уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн эсрэг ямар алхам хийхээ тодорхойлж чадахгүй байгаа үед Английн банк ийм санаачилга эхлүүлээ. Баасан гарагт Холбооны нөөцөөс бусад Англи, Герман, Франц, Япон, Хятад зэрэг дэлхийн томоохон 18 улсын төв банкны удирдлага уулзаж, уг эрсдэлд хариу арга хэмжээ авахгүй бол бүх салбарыг хамарч,

нөхөгдөшгүй хохиролд орж болзошгүйг анхааруулав. Мөн урт хугацааны эрсдэлийг бууруулахын тулд ойрын алхам хийх ёстойг төв банкууд уриалжээ. Түүнчлэн дүн шинжилгээ болон удирдан чиглүүлэх шинэ арга боловсруулах ёстой гэж үзсэн байна.

Өнгөрсөн сард Английн банкны нийтлүүлсэн судалгаанд банкуудын дөнгөж 10 хувь нь уур амьсгалын эрсдэлийг тооцохуйц алсын төлөвлөгөөтэй байгааг илрүүлжээ. Цаашлаад эрсдэлийг хангалттай тооцоогүй байгууллагад капиталын нэмэлт хасалтын арга хэмжээ авч магадгүй байгаа ч мэдэгдэлд хараахан оруулахгүй бололтой. Хэд хэдэн том банк нүүрс хүчлийн ялгаруулалт ихтэй төсөлд зээл олгох асуудлыг анхаарна гэсний дотор нүүрсний цахилгаан станц, элс олборлолт багтаж буй. Тэд түүнчлэн ногоон хөрөнгө оруулалтыг дэмжихээ амлажээ.

Гэхдээ Английн банк юуны өмнө үерийн даатгал гэх мэт эрсдэлийг сайтар цэгнэхийг шаардах бодолтой байна. Уг мэдэгдэл нь захирах гэхээс илүүтэй чиглүүлэх зорилготой

учир Английн банк цаашид сайн жишээг тусгасан илүү заавар гаргахаар төлөвлөж байгаа аж. Түүнчлэн цахим халдлага, үйл ажиллагааны эрсдэл зэрэг чиглэлээр удирдаж боловсруулж эхэлжээ. 2016 онд нэвтрүүлсэн журамд ахлах менежерүүд аль нэг асуудалд анхаараагүй бол торгох эсвэл уг тушаалд ажиллахыг хориглох зэрэг арга хэмжээ тусгагдсан. Иймээс нарийн журамлаагүй салбарт зохицуулагчид хариуцлага хүлээлгэх боломж бүрджээ.

Үүний сацуу Франц гэх мэт бусад орон уур амьсгалын өөрчлөлтийн талаар компаниудын санаа бодлыг судлах зэрэг санаачилга хэрэгжүүлдэг ч Английн банк түрүүлж ийм шалгуур гаргахаар бэлтгэв. Оксфордын их сургуулийн профессор Бен Калдекотт “Энэ бол компаниудад хандан уур амьсгалын асуудлаар гаргаж байсан хамгийн тодорхой удирдаж” хэмээн үнэллээ. Гэвч зарим хүн хэмжихэд хүндрэлтэй эрсдэлийн эсрэг эрх баригчид ийм түргэн шийдвэр гаргахдаа болгоомжтой хандахыг уриалсан



L3 ба Harris цэргийн салбарт хүчээ нэгтгэв



BBM©

Эрик Платт

L3 technologies ба Harris Corp компани бүх хувьцаагаа нэгтгэх хэлцэл байгуулж, батлан хамгаалахын салбарт дэлхийд дээгүүрт бичигдэх 33.5 тэрбум ам.долларын үнэлгээтэй групп боллоо. L3 Harris technologies гэж нэрлэх шинэ нэгдэл нь агаарын тээвэр болон цэргийн салбарт хүчээ зузаатгаж, өсөн нэмэгдэж буй батлан хамгаалахын салбар болон онгоц үйлдвэрлэлд өрсөлдөнө гэв. Harris-ийн захирал Уильям Браун “Уг хэлцлээр бид дэлхийд тэргүүлэх цэргийн технологийн компани болж байна” гэжээ.

L3-ын захирал Кристофер Кубасик Boeing, Lockheed Martin, Northrop Grumman зэрэг томоохон үйлдвэрлэгчидтэй өрсөлдөхөө нуугаагүй бөгөөд хоёр компани өсөлтийн ижил замаар явж байсан гэв. Гэрээний дагуу L3-ын хувьцааг 1.3-иун тэгшитгэж Harris-ийн

хувьцаатай солилцох юм байна. Хэлцлийг гүйцэтгэж дуусахад Harris-ийн хувьцаа эзэмшигчид хамтарсан компанийн нийт хувьцааны 54 орчим хувийг эзэмших аж. Хэлцлийг хэрэгжүүлэх эхний хоёр жилд тус компанийг ноён Браун удирдахаар томилогджээ.

Нью-Йоркт бүртгэлтэй L3-ын үнэлгээ 15.3 тэрбум ам.доллар бөгөөд АНУ, Британи болон холбоотнуудын зэвсэгт хүчинд холбооны систем, цахилгаан төхөөрөмж нийлүүлдэг. 18 тэрбум орчим ам.долларын үнэлгээтэй Harris Corp төсөөтэй төхөөрөмжийг цэргээс гадна иргэний агаарын тээврийн хяналтад зориулан үйлдвэрлэдэг. Ноён Брауны мэдэгдэлд нэгдлийн төлөвлөлтийг боловсруулж эхэлсэн бөгөөд гурав дахь жилээс гурван тэрбумын эргэлтийн бэлэн мөнгөтэй болно гэж дурджээ. Сүүлийн үед АНУ-д хийгдэж

буй нэгдлүүдийн цаад шалтгаан нь Ерөнхийлөгч Трамп цэргийн зардлыг өсгөнө гэж мэдэгдсэн явдал юм. Захирлууд түргэн өсөж буй зах зээлээс томоохон хувь хүртэхийн тулд үйлдвэрлэгч Esterline-ыг өртэй нь хамт дөрвөн тэрбумаар нэгтгэхээ зарлав.

Энэхүү нэгдэл жил хүрэхгүй хугацаанд аэроспейсийн салбарт хийгдсэн гурван томоохон хэлцлийн нэг болж байна. Morgan Stanley, Sullivan компани Harris-т зөвлөгөө өгч байгаа бол L3-ын тал Goldman Sacks ба Simpson Thacher-аас зөвлөгөө авч байна.



Эдийн засаг

Монголд хонины ноосноос ноолуур гарган авдаг боллоо

Шинэ брэнд гаргах хамгийн боломжтой зах зээл нь хойд хөрш юм

Ч.Баатар
ЗГМ

Сүүлийн жилүүдэд Монгол Улс зөвхөн уул уурхай бус мал аж ахуйн гаралтай ноос ноолууран бүтээгдэхүүнээрээ дэлхийн зах зээлд хөгжих чиглэл баримталж буй. Энэ бодлогын талаар “Могол ноос” ХХК-ийн ерөнхий захирал Ч.Эрдэнэбаттай ярилцлаа. Тэрбээр малын гаралтай эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэж дэлхийн зах зээлд гаргах боломж арвин бий гэдгийг онцолсон юм.



ЗГМ ©



-Өнгөрсөн зуны бороо нэлээд оройтсон. Энэ нь ноосны үйлдвэрлэлд сөрөг нөлөө үзүүлсэн үү?

-Тийм ээ, ялангуяа говийн нутгуудаар их гантай байсан, зун ч орой болсон. Үүнээс шалтгаалан хонины ноосны гарц муудсан. Хөрс хуурайших тусам хонины ноосон дахь тоос, шорооны агууламж ихэсдэг.

-Ноосны гарц муудсанаас үнэ, ханшид өөрчлөлт гарав уу?

-Үнийн тогтвортой бодлого байхгүй болохоор нэлээн том өөрчлөлт гарсан. 2016 онд хонины ноос кг нь 1000 төгрөг байсан бол энэ жил 4200 төгрөгт хүрч, сүүлийн хоёр жилд гурван мянга гаруй төгрөгөөр нэмэгдлээ. Ноос бэлдэж байх үед 4200 төгрөг байсан бол одоо 2800 төгрөг болсон байх жишээтэй. Энэ нь эцсийн бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдэд сөргөөр нөлөөлөх нь ойлгомжтой. Жишээлбэл, жилд таван мянган тонн ноос бэлтгэдэг компани 200 тонныг л бэлтгэлээ. Ийнхүү түүхий эдийн хомсолдол орж, Шинэ Зеландаас хонины ноос импортлоход хүрээд байна.

-Түүхий эдийн татан авалт хангалтгүй болоход импортлох зардал хэр зэрэг ялгаатай болж байна?

-Шинэ Зеландаас л гэхэд түүхий эд татахад үнэ хямд бөгөөд чанартай байсан. Гаднаас татан авалт хийж буй нь гарц хангалтгүйгээс гадна үнийн асуудлаас улбаатай. Мөн үйлдвэрлэгчид ноосоо бэлдсэн ч борлуулж чадахгүй байх тохиолдол бий. Төрөөс үйлдвэрлэлийг дэмжих тууштай бодлого дутагдаж байна.

-Таны бодлоор Хөдөө аж ахуйн бирж дотоодын түүхий эдийн арилжааг дэмжиж чаддаг уу?

-Хэрэв тус биржийн үйл

ажиллагаа зөв чиглэвэл түүхий эдийн арилжааг дэмжиж чадна. Хөдөө аж ахуйн биржийн үйл ажиллагаагаар сайн явуулдаг туршлагатай гадны орнууд олон бий. Манай улс тэдгээрийн жишгээр явж чадахгүй байгаа учраас үйлдвэрлэгчид шүүмжлээд байгаа юм. Биржийн үйл ажиллагаа жинхэнэ утгаараа явахгүй байна. Гэхдээ зөв ажиллаж чадвал амжилт гаргах боломж бий.

-Дотоодын зах зээлийг хангахад гадна боловсруулсан бүтээгдэхүүнээ гадагшаа гаргадаг гэлээ. Үүнээс өөр ямар боломжууд байдаг вэ?

-Монгол хонины ноосноос

шинэ түүхий эд гаргаж авсан. Энэ нь хонины ноосноос гаргаж авсан ноолуур юм. Ямааны ноолууртай их төстэй бөгөөд чанарын маш бага зөрүүтэй. Хонины ноосноос гаргасан ноолуур 19 мкм /микрон/ бол ямааны ноолуурынх 16 мкм байгаа юм. Энэ нь Монголд төдийгүй дэлхийн хэмжээнд шинэ бүтээгдэхүүн болж буй. Учир нь дэлхийд ноосон бүтээгдэхүүнийг Австрали хонины ноосоор жишдэг бол монгол хонины ноолуур маань шинэ түүхий эд боллоо.

Үйлдвэрлэгчдийг дэмжих төрийн бодлого дутмаг байна

Мөн сүүлийн үед ноосны салбарт хэд хэдэн шинэлэг зүйл бий болсон. Жишээлбэл, хөдөө орон нутагт нарийн утасны үйлдвэрүүд байгуулагдлаа. Ийнхүү нарийн утсаар ноосон даавуу үйлдвэрлэж, түүгээрээ ноосон пальто хийсэн. Энэ

мэтээр малын гаралтай эцсийн бүтээгдэхүүн хийх боломжууд их байна. Түүнчлэн хонины ноосноос гардаг хялгасыг бусад ашиглагдахгүй ноостой нийлүүлэн дулаалгын материал хийж туршлаа. Аливаа брэнд дэлхийн зах зээлд гарахдаа бүтээгдэхүүнээ дотооддоо үйлдвэрлэж хэрэглээд, алдаа дутагдлаа засаж, дэлхийд гардаг. Иймд тус бүтээгдэхүүнээр зөвхөн пальто биш, малгай, цамц, бэлэг дурсгалын зүйлс гэх мэтийг хийж болно. Ингэснээр брэнд болж, дэлхийн зах зээлд гарах боломж бүрдэнэ шүү дээ.

-Дэлхийн зах зээлд өрсөлдөхөд бүтээгдэхүүний загварт анхаарах шаардлагатайг онцолдог. Үүнийг сайжруулахын тулд хэрхэн ажиллаж байна вэ?

-Даяарчлалын эринд тухайн жил болон ирэх жилд дэлхийн загварын чиг хандлага ямар байхыг хялбархан мэддэг болсон учраас загварын хувьд хоцрох асуудал байхгүй. Мөн ноос, ноолуурыг хооронд нь хольж бүтээгдэхүүн хийж болох юм. Дэлхийд 100 хувь ноолууран бүтээгдэхүүн худалдан авах хэрэглэгчдийн тоо маш бага байдаг. Хэрэв 20, 30 хувийн холиотой бүтээгдэхүүн хийвэл яг ноолуур шиг мэдрэмж төрүүлэхээс гадна хямд үнэтэй байх учраас худалдан авах хэрэглэгчдийн тоо олширно.

-Тэгвэл бүтээгдэхүүний чанар болон эдлэгчид хэр зэрэг ялгаа гарах бол?

-Эдлэгчийн хувьд бараг ялгаагүй. Магадгүй ноосон бүтээгдэхүүн илүү удаан эдлэгчтэй байх. Мөн Монгол Улс шиг уур амьсгалтай оронд хонины ноос илүү дулаахан. Түүнчлэн ноос амьсгалдаг учраас биед шингэсэн утааг ч гадагшлуулдаг.

-Эцсийн бүтээгдэхүүн гаргах хамгийн боломжтой зах зээл хаана гэж бодож байна вэ?

-Хамгийн боломжтой зах зээл манай хойд хөрш юм. Яагаад гэвэл, цаг агаарын хувьд болон хэрэглээний түвшин нь манай улстай ойролцоо. [ЗГМ]

ЗГМ ТОВЧХОН

» АРИЛЖАА

22

Компани. Монголын хөрөнгийн бирж даваа гарагт 22 компанийн 301,915 ширхэг хувьцаа арилжлаа. Энэ өдөр есөн компанийн хувьцааны ханш өссөн бол 11 компанийнх буурч, хоёр компанийнх тогтвортой байв. Үүнээс “Женко Тур Бюро” болон “Адуунчулуун” компанийн хувьцааны ханш хамгийн өндөр өслөө.

» ИНДЕКС

2.4

Их наяд төгрөг. Top 20 индекс 20463.69 нэгж боллоо. Ингэснээр зах зээлийн үнэлгээ нь 2.4 их наяд төгрөгтэй тэнцэв.

» АЛТ

1,229

Ам.доллар. Алтны спот ханш 0.98 хувиар өсч, 1,229 ам.доллар болжээ.

» ГАЗРЫН ТОС

71.3

Ам.доллар. WPI төрлийн газрын тосны ханш 0.32 хувиар өсч, 71.3 ам.долларт хүрлээ.

» ХАРИЛЦАА ХОЛБОО

13.6

Хувь. 2018 оны эхний хагас жилд Монгол Улсын интернет хэрэглэгчдийн тоо 2.9 саяд хүрч, жилийн өмнөхөөс 13.6 хувиар өссөн байна. Үүний 2.6 сая нь суурин интернет хэрэглэгчид бөгөөд өмнөх жилээс 22.5 хувиар нэмэгджээ.

» ЭРЧИМ ХҮЧ

Цахилгаан дулаан, эрчим хүч үйлдвэрлэгч, дамжуулагч компаниудын өвөлжилтийн бэлтгэл төлөвлөгөөний дагуу хэвийн байгаа бөгөөд одоогоор 94-98 хувийн гүйцэтгэлтэй байна.

ВАЛЮТЫН ХАНШ

АНУ-ын доллар	2,564.65
Евро	2,966.66
Японы иен	22.94
ОХУ-ын рубль	39.01
БНХАУ-ын юань	370.22
БНСУ-ын вон	2.26

КОМПАНИ

OZD CAPITAL: Centerra Netherlands болон Centerra Gold Mongolia-г худалдан авлаа

О.Одгэрэл
Шинжээч

Австралийн Брисбенд төвтэй OZD Capital компани OZD Asia компаниараа дамжуулан Монголд хөрөнгө оруулсан тухайгаа мэдээллээ. Өөрөөр хэлбэл, Centerra Netherlands болон Centerra Gold Mongolia компаниудыг

худалдан авах замаар Монголын уул уурхайн төслүүдэд хөрөнгө оруулалт хийгээд байна. Centerra Gold Mongolia компани Монгол дахь “Бороо гоулд” компанийн 100 хувь хөрөнгө оруулагч юм. OZD Capital нь OZD Asia компанийн толгой компани бөгөөд хөгжиж буй зах зээлд төвлөрч ажилладаг. Ялангуяа, уул уурхайн салбар болон металлын

активуудад санхүүжилт хийж хөрөнгө оруулахын зэрэгцээ үйл ажиллагааг нь сайжруулахад чиглэн ажилладаг ажээ. Компанийн хөрөнгө оруулалт нь Австрали, Сингапур болон Монголоос голчлон бүрддэг байна. OZD Capital компанийн ТУЗ-ийн гишүүн Кельвин.М “Энэхүү хэлцэл нь хөгжиж буй зах зээлүүдэд ялангуяа,

үнэт металл болон суурь металлуудын зах зээлд хөрөнгө оруулах, улмаар активуудын үйл ажиллагааг нь сайжруулахад чиглэсэн компанийн үндсэн стратегид нийцэж байна” гэж онцолжээ.

OZD Capital нь Ази болон Өмнөд Америк, Баруун Африкт үнэт металлын активуудтай гэж мэдээллээ. Тус компанийн үндсэн

оффис нь Австралийн Брисбенд байрладаг бөгөөд Сингапур болон Монголд оффистой юм. Харин хэлцлийг хийсэн OZD Asia нь Сингапурт бүртгэлтэй ажээ. Монгол дахь төслүүдийн хэлцлийн дүн 35 орчим сая ам.доллар бол нийт хэлцлийн дүн 90 орчим сая ам.доллар болсон гэж OZD Capital компани мэдээллээ.

ТЕНДЕРИЙН УРИЛГА

Огноо: 2018 оны 10 дүгээр сарын 16-ны өдөр

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН НЭР: ДУНД ДАРАЛТЫН ХААЛТ НИЙЛҮҮЛЭХ
ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ДУГААР: MC-120/2018
“ДЦС-4” ТӨХК нь эрх бүхий тендерт оролцогчдоос **“ДУНД ДАРАЛТЫН ХААЛТ”** нийлүүлэх тухай цахим тендер ирүүлэхийг урьж байна.

Энэхүү тендер шалгаруулалт нь цахим худалдан авах ажиллагааны системээр зарлагдаж байгаа цахим тендер тул www.tender.gov.mn хаягаар орж дэлгэрэнгүй мэдээлэл болон цахим тендерийн баримт бичгийг үнэ төлбөргүйгээр татан авна уу.

Тендер оролцогч нь тендер илгээхийн өмнө **50.000 /тавин мянга/** төгрөгийг цахим систем ашиглан төлсөн байх ёстой.

Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **45 хоногийн** дотор хүчинтэй байна.

Тендер оролцогч нь санхүүгийн болон туршлагын дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

1. Борлуулалтын хэмжээ: Сүүлийн 2 жилийн жил бүрийн борлуулалтын орлого нь санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.,2016, 2017 он тус бүрээр

2. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Тендер санал болгож буй үнийн дүнгээс багагүй байна.

3. Сүүлийн 2 жилд хэрэгжүүлсэн ижил төстэй ажлын өртөг: Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 2016,2017 тус бүрээр /нотлох баримтын хамт/ сүүлийн 2 жилийн дүн Тендер санал болгож буй үнийн дүнгээс багагүй үнийн дүнтэй ижил төстэй гэрээт ажил гүйцэтгэсэн байна.

Тендерийн хамт тендер санал болгосон үнийн дүнгийн 2%-тай тэнцэх дүнтэй тендерийн баталгаа ирүүлнэ.

Засгийн газрын бондоор ирүүлсэн тендерийн баталгааг хүлээн зөвшөөрнө.

Тендерийг **2018 оны дугаар 11 сарын 19-ны өдрийн 10.00 цагаас өмнө** цахим системээр илгээх ба нээлтэд оролцох хүсэлтэй тендер оролцогчдыг байлцуулан тендерийг **2018 оны 11 дугаар сарын 19-ны өдрийн 10 цаг 30 минутад** нээнэ.

Гадаадын этгээд тендер ирүүлэх **эрхтэй.**

Монгол улсын гарал үүсэлтэй бараанд давуу эрх **тооцохгүй.**

Сонирхсон этгээд бусад мэдээлийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20 дугаар хороо, Эрчим хүчний гудамж, “ДЦС-4” ТӨХК-ийн Захиргааны байр, 3 дугаар давхар, 312, 313 тоот өрөө Худалдан авах ажиллагааны хэлтэс
Утас 7018-1309, 7000-1357, 7017-1357, Факс 7018-13097000-1357



MICROSOFT OFFICE 365 BUSINESS ПРОГРАМЫН ЛИЦЕНЗИЙН ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

Огноо: 2018 оны 10-р сарын 12-ны өдөр

“МИК ОССК” ХХК нь албан ёсны борлуулах эрх бүхий нийлүүлэгчээс **Microsoft Office 365 Business** програмын **100 ширхэг лицензийг** 1 жилийн хугацаагаар сунгах, **шинээр 20 ширхэг лицензийг** 1 жилийн хугацаатай нийлүүлэх үнийн санал ирүүлэхийг урьж байна. Үүнд:

Нийлүүлэгчдэд тавигдах шаардлага:

- Нийлүүлэгч компанийн товч танилцуулга;
- Тухайн бүтээгдэхүүнийг албан ёсоор худалдан борлуулах эрхийг илтгэсэн баримт бичиг;
- Тухайн чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлуудын талаархи танилцуулга;

Үнийн саналыг дээр дурдсан шаардлагуудын хамтаар **2018 оны 11 сарын 19-ны өдрийн 18:00 цагаас өмнө munkherdene@mik.mn** хаягаар ирүүлнэ үү.

Утас: (976-11) 328267 / дотуур дугаар 850

Эдийн засаг

Шатахууны үнэ, валютын ханшийн өсөлт инфляцид хүчтэй нөлөөлөхгүй

Б.Баярмаа
@bayarmaaZGM

Шатахууны үнэ өсөхтэй зэрэгцэн хүнс, барааны үнэ нэмэгдэх нь гэсэн хүлээлт олон нийтийн дунд бий болжээ. “Шатахууны үнэ нэмэгдэхээр өргөн хэрэглээний барааны үнэ дагаад өснө. Ирэх саруудад Шинэ жилийн баярыг угтаад юмны үнэ улам л нэмэгдэх байх” гэж иргэн Ш.Алтангэрэл ярилаа. Инфляц өндөр байх нь иргэдийн цалин, орлогыг үнэгүйдүүлдэг тул

хоёр сард инфляцид төдийлэн хүчтэй нөлөө үзүүлэхгүй гэдгийг төв банк онцолж байна.

Монголбанк 2018 онд улсын хэмжээнд инфляцыг наймаас доошгүй хувьд барих зорилт тавьсан. Оны эхэнд тус үзүүлэлт 6.9 хувьтай байсан. Харин долдугаар сард 7.7 хувьд хүрч өссөн бол есдүгээр сард энэ оны хамгийн доод түвшинд буюу 5.7 хувьд хүрч буулаа. Өнөөдөр улсын хэмжээнд инфляц тухайн үеийнхээс бараг тав дахин бага байна. Тэгвэл 2018 оны отгон саруудад инфляцын энэ намжмал байдал хэвээр хадгалагдах болов уу? Энэ оны төгсгөлд Монголбанкны бодлого инфляцыг зорилтот түвшиндээ барьж чадах болов уу?

Зургаа орчим хувьтай байгаа хэрэглээний үнийн индекс ирэх хоёр сард өсөх бус харин ч буурах магадлалтай байгаа аж. Төв банк эдийн засгийн өсөлттэй уялдан

Мах, ногооны үнэ инфляцыг хазаарлана

тэрбээр ийнхүү зовниж буй.

Манай улс импортын шатахуунаас бүрэн хараат учраас үүнийг дагаад тээврийн зардал, цаашлаад өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүн дэлгүүрийн лангуунаас хэрэглэгчийн гар дээр очих үнэ нь өсдөг. Түүнчлэн сүүлийн саруудад ам.долларын ханш огцом нэмэгдсэн нь бараа, бүтээгдэхүүний үнэ өсөхөд тодорхой хэмжээгээр нөлөөлөхөөр байна. Энэ онд импорт тэлж, гадаад өрийн хүүний төлбөр өссөн нь гадаад валютын эрэлтийг нэмэгдүүлж, төгрөгийн ханш сулрахад нөлөөлсөн.

Гэхдээ эдгээр хүчин зүйлс ирэх



Мах, ногоо зэрэг монголчуудын хүнсний хамгийн өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ хямдарсан нь инфляц буурахад нөлөөлжээ. Едүгээр сард махны үнэ тав хүртэлх хувиар хямдарсан бол ногооных 19.4 хувь хүртэл буурчээ.

С.Батсайхан / ЗГМ©

● Инфляц есдүгээр сард энэ оны хамгийн доод түвшинд буюу 5.7 хувьд хүрч буулаа.

● Шатахууны үнэ, валютын ханшийн өсөлт инфляцид том ачаа болохгүй.

● 2019-2020 онд жилийн найман хувь, дунд хугацаанд зургаан орчим хувьд тогтворжуулах зорилтыг үргэлжлүүлэхээр 2019 оны улсын төсвийн төсөлд тусгажээ.

эрэлтийн гаралтай инфляц нэмэгдэх, дэлхийн зах зээл дээрх шатахууны үнэ өсөх зэрэг хүлээлт байгаа ч нийлүүлэлтийн хүчин зүйлсийн нөлөөгөөр эдгээр нь саарх төлөвтэй гэж үзэж байна. “Шатахууны үнэ, валютын ханшийн өсөлт инфляцид том ачаа болохгүй. Эдгээр хүчин зүйлсийн нөлөөг мах, ногоо зэрэг өргөн хэрэглээний барааны үнэ буурснаар нөхөх боломжтой. Тиймээс 2018 оны төгсгөлд инфляц Монголбанкны зорилтот түвшинд буюу наймаас бага хувьд байх төлөвтэй” гэж Төв банк тайлбарлалаа.

Хүнсний бараа, ундаа, усны үнэ 2017 оны есдүгээр сард 7.5

хувьтай байсан бол өнгөрсөн сард 4.2 хувьтай гарсан. Харин хамгийн сүүлийн статистикаас харвал, энэ сарын эхний 10 хоногийн байдлаар гол нэрийн барааны үнэ өмнөх сарынхаас 2.1, өмнөх оны мөн үеийнхээс 0.3 хувиар буурсан байна. Энэ нь сүүлийн хэдэн сард мах, ногоо зэрэг монголчуудын хүнсний хамгийн өргөн хэрэглээний бүтээгдэхүүний үнэ хямдарсантай холбоотой. Махны үнэ тав хүртэлх хувиар хямдарсан бол ногооных 19.4 хувь хүртэл буурчээ. Харин гурилын үндэс өөрчлөлт ороогүй. Ирэх хоёр сард ч энэ байдал хадгалагдах төлөвтэй байгаа аж.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамнаас Онцгой албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах саналаа Засгийн газарт өгсөн. Мөн ОХУ-ын “Роснефть” компанитай хэлэлцээр хийж буй. Дэлхийн зах зээл дээрх шатахууны үнэ буурахгүй байсан ч нийлүүлэлтийн сүлжээнд нь татаас олгох байдлаар үнийн өсөлтийг хазаарлах бодлого хэрэгжүүлэх талаар яригдаж эхэлсэн. Хэрэв эдгээр бодлого хэрэгжвэл шатахууны үнээс үүдэн инфляц өсөх магадлал буурна.

Инфляц сүүлийн таван жилийн доод түвшиндээ хүрээд байгаа. 2008 онд тус үзүүлэлт 22.1 хувьд

хүрч байсан бол 2013 онд 12.5 хувьд болж байсан. Харин 2015, 2016 онд тэг рүү нэлээн дөхсөн бол өнөөдрийн байдлаар зургаан хувьтай байгаа.

2018 оны эцэст инфляц наймаас бага хувьтай гарах төлөвтэй

Тэгвэл ирэх 2019-2020 онд жилийн найман хувь, дунд хугацаанд зургаа орчим хувьд

тогтворжуулах зорилтыг үргэлжлүүлэхээр 2019 оны улсын төсвийн төсөлд тусгаад буй.

Инфляц нэг оронтой тоонд буюу нам түвшинд байх нь иргэдийн бодит орлогыг хамгаалдаг бол хэлбэлзэл багатай, тогтвортой байж бизнесийн макро орчны тодорхой бус байдлыг бууруулдаг. Ялангуяа, 6-8 хувь байх нь гадаад эрэлт, түүхий эдийн үнийн хэлбэлзэл өндөр байгаа энэ үед эдийн засгийн идэвхжил, ажил эрхлэлтийг бүх салбарт дэмжих нөлөөтэй. Үүний зэрэгцээ иргэдийн дундах инфляцын талаарх хүлээлтийг тогтворжуулахад ач холбогдолтой. [ЗГМ]

ЗАХ ЗЭЭЛИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ:

